

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ  
4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТӨРИЙН УДИРДАЛАГЫН ХҮРЭЭНД

Төрийн албаны тухай хууль болон түүнийг дагалдан гарч байгаа Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн тогтоолуудыг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгөх, сумдын төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байгаа болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах бэлтгэл ажил, төрийн албан хаагчийн хувийн хэрхэн бүрдүүлж байгаа зэргийг газар дээр нь үзэж арга зүйн зөвлөгөө өгөх ажлаар 13 суманд ажлын хэсэг ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн төрийн жинхэнэ албан хаагчийн дэлгэрэнгүй судалгааг аймгийн хэмжээний төрийн захиргааны албан хаагчдаар нэгтгэн хүргүүлсэн

Аймгийн соёл урлагийн салбарын ажилтнуудын зөвлөгөөнд Төрийн албаны тухай шинэ хууль, түүнийг дагалдан гарсан тогтоол, шийдвэрийн талаар сургалт мэдээлэл хийлээ.

Удирдлагын академийн онлайн зайны сургалтад Засаг даргын Тамгын газрын 6 мэргэжилтэн суралцаж, сертификат гардан авлаа

Бүх сумын Тамгын газрын дарга нарыг Канадын мерит төсөлтэй хамтран зохион байгуулсан “Цагийн төлөвлөлт, байгууллагын хамтын ажиллагаа сургалт, семинарт хамрууллаа.

Хэрэглэгчийн үнэлгээний үр дүнг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын ХЭГазарт хүргүүллээ. 2018 оны Хяналт, шинжилгээ-Үнэлгээний мөрөөр 13 сум, 26 агентлаг, байгууллагуудад зөвлөмж хүргүүллээ. ХШҮнэлгээний чиглэлээр салбар, агентлаг, орон нутгийн байгууллагууд өөр хоорондоо харилцан суралцах, байгууллагын чадавхийг бэхжүүлэх, цаашид түгээн дэлгэрүүлэх боломжтой гэж үзсэн 3-н сайн туршлагыг сонгон МУ-ын ЗГХЭГ-ын ХШҮДАГазарт хүргүүллээ.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2019 онд объектын гал түймэр 21, Ой хээрийн түймрийн дуудлага 1, Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний тохиолдол 1 удаа, хүчтэй шороон шуурга 1 удаа тус тус бүртгэгдээд байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Орон нутгийн хөгжлийн санд орлогын шилжүүлгээр 807,8 сая төгрөг, хандиваар 316,6 сая төгрөг, улсын төсвөөс 4132,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч орон нутгийн төсөвт 2310,3 сая төгрөгийн орлого орж, орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 6543,3 сая төгрөг хийгдлээ. Үүнээс сумдад санхүүгийн дэмжлэгээр 1509,8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал 1850,9 сая төгрөг, соёлын шилжүүлгийн байгууллагуудад 894,9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлгээр 2451,6 сая төгрөг, Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгээр 4920,0 сая төгрөг, Газрын харилцаа кадастрын тусгай зориулалтын шилжүүлгээр 116,8 сая төгрөг, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгээр 1360,8 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орлогын шилжүүлэг 807.8 сая төгрөгөөс сумдад хуваарийн дагуу 130,0 сая төгрөг, 4 сарын байдлаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 193,1 сая төгрөгийг тус тус шилжүүлж санхүүжүүлсэн байна. Мөн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, бүрэн хураалтын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон ОНХС, УТХО-ын

ажлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан дүгнэлт гарч, дүнгийн хурлыг аймгийн аудитын газартай хамтран бүх сумдын төсвийн эрх захирагч, санхүүгийн албаны дарга, ОНХС хариуцсан нягтлан бодогч, үнэлгээний хорооны дарга болон холбогдох хүмүүсийн төлөөллийг оролцуулан зохион байгууллаа. Нийтлэг гарч буй алдаа, зөрчил, дутагдлыг танилцуулан харилцан ойлголцох, зөвлөн туслах чиглэлээр дүнгийн хурлыг зохион байгууллаа.

#### Хяналт шалгалтын талаар:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний дагуу Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Тус алба нь 2019 оны 4 дүгээр сард албаны даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Мөнххаан, Түмэнцогт сумдын 12 төсөвт албан байгууллага, 6 сан, 2 ОНӨААТҮГ-ын 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Тус шалгалтаар улсын ахлах байцаагчийн 14 актаар 84290.6 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 240234.1 мянган төгрөгийн зөрчилд, зөрчлийг арилгуулах 4 албан шаардлага хүргүүлж, 3 танилцуулга гаргалаа.

#### ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

##### Байгаль орчин, уул уурхайн чиглэлээр:

Монгол жүюаньли ХХК-ны ирүүлсэн хүсэлтийг судлан Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу холбогдох газраар ус ашиглах дүгнэлтийг гаргуулж тус хуулийн 28.6-т зааснаар ус ашиглах зөвшөөрөл авч мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулж, тоолуурын заалтыг үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллах тохиолдолд дээрх аж ахуй нэгжийн шавхан зайлуулах усыг баяжуулах үйлдвэрт ашиглахаар гэрээ байгуулан ажиллахыг зөвлөлөө.

Иргэдийн ухамсар- эрүүл хоггүй орчин аяныг аймгийн ЗДТГ, МХГ, Баруун-Урт сумын ЗДТГ, Сүхбаатар-Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Буйр нуур мэнэнгийн талын сав газартай хамтран 04-р сарын 17-аас 06-р сарын 17-ны хүртэлх хугацаанд зарлаж нээлтийг зохион байгууллаа. Аяны зорилго нь Хог хаягдлын тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтийг хангуулах, хог хаягдлыг ил задгай хадгалах, шатаах, гудамж талбайд асгаснаас үүсэх хортой бодисоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор нөлөөллийг бууруулах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хоггүй цэвэрхэн орчинд амьдрах зөв хандлагад уриалах, улмаар хотын өнгө үзэмж, тохижилтыг нэмэгдүүлэх явдал юм.

Аяны хүрээнд

- 1.Өөрчлөлтийг өөрөөсөө- хандлагаа өөрчилье сэдэвт иргэд олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг
- 2.“Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд иргэн таны оролцоо” болзолт уралдаан
- 3.“Хог хаягдал ба хяналт” арга хэмжээ
- 4.1 хүүхэд 1 даавуун уут, 1 ААН 100 даавуун уут арга хэмжээ
- 5.Хоггүй ирээдүй биднээс эхэлнэ багуудын цэвэрлэгээ, бүх нийтийн цэвэрлэгээ

6. Даавуун уут төсөл

7. Авто машингүй цэвэр агаарт хамтдаа арга хэмжээ

8. "1 уут хог 1 сугалаа" хүүхдийн баярын арга хэмжээ

9. Хогоо эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшигчээ /ангилан ялгадаг хогийн сав байршуулах, иргэдийн оролцоотой хогийг ангилан ялгах туршилт/

Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэг болон Таван эрдэнэ хорооллын хогийн цэгийг цэгцлэх гэсэн ажлууд хийхээр төлөвлөөд байна. Энэхүү ажлын нэг болох Өөрчлөлтийг өөрөөсөө-Хандлагаа өөрчилье сэдэвт олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөнийг хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд иргэд олон нийтийн оролцоог хангах, хоггүй цэвэрхэн орчинд амьдрах зөв хандлагад уриалах зорилготой зохион байгуулсан ба зөвлөгөөн хэлэлцүүлэгт албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл болсон 83 хүн хамрагдлаа. Хэлэлцүүлгийн үеэр иргэдээс Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах журмын төсөл, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын төсөлд тус тус санал авсан.

Хог хаягдлыг ангилан ялгадаг 3.5 тн багтаамжтай 15 ширхэг хогийн сав /1ш нь 666000 төг/-ыг орон сууцны хороолол болон зарим гэр хороололд байршуулаад байна.

Баруун-урт сумын төвлөрсөн хогийн цэгийг цэгцлэх, аюултай хог хаягдлын байгууламж, хашаа хамгаалалт хийх ажлыг эхлүүлээд байна. Уг ажилд зориулан БОАЖГ-аас 10 сая төгрөгний санхүүжилт хийн "Сүхбаатар-тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлж байна.

Наран сумын Хөдөө аж ахуйн тасаг, багийн засаг дарга нартай хамтран хөдөөгийн малчин айл өрхийн дунд "ЦЭВЭРЧ ХОТ АЙЛ ӨРХ" шалгаруулах 10 сарын аяныг зарлалаа. Уг аяны зорилго нь сумын малчид нийт иргэд хог хаягдалгүй цэвэр орчныг бүрдүүлэн соёлч байдлыг хэвшүүлснээр орчны бохирдлыг арилгаж хүрээлэн буй орчин, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, тохилог цэвэрч үзлийг төлөвшүүлэхэд оршино. Хугацааны хувьд 12 сарын 7-ныг хүртэл үргэлжлэх бөгөөд шалгуур үзүүлэлтийн дагуу 3 байр шалгаруулах юм.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр аймгийн Засаг дарга сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга сумдын нутагт Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлын цахим тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчээр "Авралын эрэлд" ХХК шалгарч гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Сүхбаатар сумын Дархан хаан ууланд нутагшиж байгаа Аргаль хонинд тандалт судалгааг энэ сард хийлээ ууланд нутагшиж байгаа Аргаль хонь хэвийн нутагшиж байна. Мөн 3-н аргаль хонь одоогийн байдлаар төллөж 3 хургатай болсон байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүх сумдын Засаг дарга нараар түймрийн эрсдэлийн улиралд ой хээрт амралт аялал зугаалга болон ой хээрт бүх төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон Захирамж гаргуулж газрын дарга сумдын Засаг дарга нарын хамтран баталсан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх Улсын Онцгой комисс, аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд төлөвлөгөө гарган хүргүүлээд байна.

Баруун-Уртын голын хашаа хамгаалалтыг шинэчлэх тендерийг 04 дүгээр сарын 05-нд цахимаар зарлаж Сүхбаатар Тохижилт-Үйлчилгээ ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр болоод байна.

Бэлчээрийн зориулалттай худаг гаргахад анхаарах асуудлын талаар сумдад Зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 10 дугаар ангийн хүүхдүүдэд Аймгийн аялал жуулчлалын давуу тал, аялал жуулчлалын мэргэжлээр сурахад анхаарах асуудал, Харилцааны ур чадвар чиглэлээр сургалт зохион байгууллаа.

Засгийн газрын 179 дүгээр тогтоолын дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж уурхай ашиглах, үйлдвэр барихтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сайн дурын

үндсэн дээр орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээг 8 ААН-тэй аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн захирал нар гурвалсан гэрээг байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/147дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Цайрт минерал” ХХК, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-иудтай хэлцэл хийх уулзалтыг зохион байгууллаа.

Аймгийн төвийн 4-р тойргийн хатуу хучилттай авто замын тендер зарлах ажлын техникийн тодорхойлолт боловсруулсан.

#### Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал аж ахуйн бодлогын зохицуулах газарт энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн газар доорх усны геофизикийн хайгуул хийх 41 уст цэгийн мэдээллийг 13 сумаас нэгтгэлээ.

Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар, Түмэнцогт, Мөнххаан суманд отрын бүс нутгийг чөлөөлөх, зөвшөөрөлгүй гаргасан худаг, хашаа хороо, барилга байгууламж харьяалалгүй суурьшиж буй малчдыг 14 хоногийн дотор нутаг бэлчээрийг чөлөөлөх мэдэгдэх хуудас өгөх ажлыг сумын ЗДТГазартай хамтран зохион байгуулж, хяналт шалгалтыг ирэх 5 дугаар сард давтан хийхээр тогтсон.

Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнд үлийн цагаан оготнотой тэмцэх талбай, зураглалыг хүргүүлсэн. Сумдаас үлийн цагаан оготнотой микро биологийн аргаар тэмцэх хорны захиалгыг авч холбогдох компанитай хамтарч сумдад тэмцэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Төллөвөл зохих 1,633.0 эх малын 66,3 хувь болох 1083.1 мянган эх мал төллөж гарсан төлийн 98 хувь болох 1056.4 мянган төл бойжиж байна 4 сарын 25-ны байдлаар 11227 толгой том мал буюу нийт том малын 0,3 хувь нь хорогдоод байна, Үүнд тэмээ 13, адуу 1053, үхэр 384, хонь 5243, ямаа 3619 байна.

#### Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Мэргэжлийн байгууллагуудаас хамтран Эрүүл мэндийн газар дээр 2019-03 дугаар сарын 28 ны өдөр "Давсны хэрэглээг бууруулах" сургалтыг аймгийн төвийн болон сумдын сургууль цэцэрлэгийн тогооч 50 гаруй тогооч нарыг хамруулан зохион байгуулж, оролцогчдод давсны хэрэглээг бууруулах, хэрэглэж буй хоолны технологийн карт хөтлөх талаар зөвлөгөө өгч ажилласан ба давсны хэмжээг бууруулсан хоолны амталгаа хийлгэж, туршлага хуваалцах ажлыг зохион байгууллаа. Мөн “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын саналыг авч нэгтгэн, зардлын тооцоог төлөвлөж байна.

Орон нутгийн хяналтын постоор дамжин нийслэлийн хүн амын хэрэгцээнд нийлүүлэгдэж буй махны мэдээллийн 7 хоног бүр гарган ХХААХҮЯ-нд хүргүүлж байна. 4 дүгээр сарын 18-наас 25-ныг хүртэл хугацаанд адууны мах 22,5 тн, үхэр 14,0 тн, хонь 11,0 тн, ямаа 7,5 тн бүгд 55,0 тн мах Улаанбаатар хот руу тээвэрлэгдсэн байна.

ХХААХҮЯамнаас Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.

4 дүгээр сарын 10-ны өдөр төрийн ордонд зохион байгуулагдсан Монгол улсад Атар эзэмшсэний түүхт 60 жилийн ойн нээлтийн арга хэмжээ, тариаланчдын улсын зөвлөгөөнд 15 тариаланч, мэргэжилтэн оролцлоо.

Сүхбаатар сумын Найрын дэнж дэх 13га бүхий тариалангийн талбайг бүрэн ашиглахаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу ХХААХҮЯ-наас хоёр ширхэг 50 морины хүчин чадал бүхий трактор, 6\*20 харьцаатай 6 ширхэг хүлэмжийг татан аваад байна.

### Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

04-р сарын 25- ны байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 876 иргэнээс эмэгтэй 425, бүртгэлтэй ажилгүй иргэн 677 иргэнээс , эмэгтэй 325 иргэн байна. 136 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 119 иргэнийг ажилд зуучилсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 53 иргэн буюу 44.5% нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 82 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.

04 дүгээр сарын 10-ны өдөр Баруун-Урт сумын ажил хайгч 27 залууг “Цайрт минерал” ХХК-ний баяжуулах үйлдвэртэй танилцуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, үйл ажиллагаа, хүчин чадал, ямар шалгуур хангасан ажилчид ажилладаг зэрэг мэдээллийг Баяжуулах үйлдвэрийн дэд дарга танилцуулав.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний хүрээнд 67 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд бүртгэлээ.

Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлтийг нэмэгдүүлж хугацаа хэтэрсэн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилгоор “Эргэн төлөлтийн сарын аян” зохион байгуулж давхардсан тоогоор 159 иргэний 102,770.9 мянган төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлж, авлагыг бууруулж ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний болон дэмжих үйлчилгээний чиглэлээр 236 иргэнд мэдээлэл өгч, 73 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсан.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд 14 байгууллага, 4 сумын ХАБЭА-н ажилтан, удирдах ажилтан, ажилчдад ХАБЭА-н сургалт зохион байгуулж, 252 иргэнийг хамруулж гэрчилгээ олгосон. Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран 4 байгууллагад ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийн шалгалт хийлээ. Уг шалгалтаар ХААН, Төрийн банк нь Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн авч ажиллуулаагүйн төлбөрийг төлүүлэхээр ХААН банканд 5,112.0, Төрийн банканд 5,184.0 төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд төвлөрүүлэх нэхэмжлэл өгөөд байна.

Аймгийн МСҮТ-тэй хамран албан байгууллага, сумдын удирдлагууд болон ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнууд ХАБЭА-н сургалтыг тус тус зохион байгуулж гэрчилгээ олголоо. Тус сургалтад Дөрвөлж ХХК-ны 97 ажилчин, Хөгжимт жүжгийн театрийн-37, Баруун-Урт сумын 11 цэцэрлэг, Боловсрол өргөө дотуур байр 14, Уулбаян сум 20, Түвшинширээ сум 33, Баяндэлгэр сум 17, Сүхбаатар сум 23, ХХҮГазар “Залуучуудын хөгжлийн хөтөч, хүний нөөц” сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан бүртгэлтэй ажилгүй өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд зориулсан Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдаж байгаа 73 иргэд тус тус хамрагдсан байна.

ХАБЭА-н сарын аянаар зохион байгуулж байгаа байгууллагуудаас нийт 3 шторк 1000ш гарын авлага, материал бэлтгэн албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргээд байна.

ХАБЭА-н сарын аяны шторк мэдээ мэдээллийг орон нутгийн SB телевиз, Фокус цахим телевиз, Сүхбаатар-агентлаг-төсөвт байгууллагын нэгдсэн фэйсбүүк групп болон Сүхбаатар аймаг ХАБЭА-н мэргэжилтэн нэгдсэн группээр дамжуулан мэдээллийг хүргэж ажиллаа.

### Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралтын 2019 оны 6 дугаар ээлжид 30 ахмад настан амарч сэргээн засах физик эмчилгээ, бариа засал, бумба, шарлага, утлага, зөгийн балны татлага зэрэг эмчилгээнүүдийг үзүүллээ. Энэ ээлжид зорилтот бүлгийн 8 ахмад настныг 5 хоногийн хугацаатайгаар амруулж 320000 төгрөгийг хүнсний эрхийн бичиг өглөө. Мөн аймгийн нэгдсэн эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг, хиймэл шүдний протезонд хамрууллаа.

Баруун-Урт сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдтэй ХХҮГ-н удирдлага, мэргэжилтэн нар 4 дүгээр сарын 03-нд уулзалт зохион байгуулж нийгмийн халамжийн тухай

хууль, журамд орсон өөрчлөлтийг танилцуулж, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн, анхаарах асуудал, цаашид хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар хэлэлцлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ийн дарга, мэргэжилтнүүд “Цагдаагийн газар” хамтран Баруун урт сумын зорилтот өрхийн хөдөлмөрийн насны 48–н иргэнд “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүүхдийн эрх ба үүрэг”, “Зөрчлийн хууль” зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа.

2019 онд амьжиргааг нь дээшлүүлэхээр сонгож авсан өрхүүдэд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад 54-н өрхийн төлөөлөл оролцож өрхийн хөгжлийн үнэлгээний дэвтрийг боловсрууллаа.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгээр ажиллах төсөлд хамрагдах иргэдийн төслийг Баруун-Урт, Халзан сумаас 2 төсөл ирж байгуулагдсан ажлын хэсгээр хэлэлцүүлэх шатанд явж байна. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаагүй, хамрагдах хүсэлт гаргасан 15 өрхөд судалгааг хийж мэдээллийг программд оруулсан.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд хүүхдийн мөнгөтэй холбоотой 11 өргөдөл, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээтэй холбоотой 3 өргөдөл тус тус ирсэн. Ирсэн өргөдлийг програмд шивж жагсаалтыг судалгаа хариуцсан мэргэжилтэнд гаргаж өгч судалгаанд хамруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 04 сард 2 удаа хуралдаж, 18 хүүхдээс 13 хүүхдийн асаргаа сунгагдаж, 3 хүүхэд асаргаа шинээр тогтоолгож, 1 хүүхдийн асаргааг цуцалж, рашаан сувилалд амруулах шийдвэрүүдийг гаргасан байна.

#### Биеийн тамир, спортын чиглэлээр:

“Хүн амын бие бялдар хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлал” сургалт зохион байгуулж, байгууллагуудын арга зүйч, биеийн тамирын багш нар нийт 23 алба хаагчид хамрагдсан. Хүн амын бие бялдар хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил байгууллагуудын 100 гаруй албан хаагч нараас авсан.

Улсын аварга, Бүсийн нэрэмжит, ААШ шалгаруулах тэмцээнд баг тамирчид амжилттай оролцлоо. Үүнд:

Шри ланк улсын Калутара хотод зохиогдсон Ази тивийн аварга шалгаруулах өсвөр үеийн шатарчдын тэмцээнээс Ц.Анударь тэргүүн байр,

Баян–Өлгий аймагт зохион байгуулагдсан 12-15 насны Улсын аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдааны 12 насны ангилалд Э.Бямбажав түрүүлсэн, 13-15 насны ангилалд Э.Дашпунцаг, Б. Сосорбарам нар шагналт байранд орж, багаараа 4 дүгээр байр,

Аэробик гимнастикийн өсвөр үеийн 15 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээн 4 дүгээр сарын 13-14- ний өдрүүдэд Орхон аймгийн Эрдэнэт хотод зохион байгуулагдаж 6-8, 9-11, 12 -14 насны 3 насны ангилалд 21 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 6-8 насны ангиллын ганцаарчилсан эмэгтэй төрөлд Г.Сондор 3 дугаар байр хүрэл медаль,

М.Нандин–Эрдэнэ 4 дүгээр байр,

ганцаарчилсан эрэгтэй төрөлд Б.Төрбаяр 5 байр,

Хосын төрөл М.Нандин–Эрдэнэ, Б. Төрбаяр 3 дугаар байр хүрэл медаль,

9-11 насны ангилалд ганцаарчилсан эрэгтэй төрөлд Б. Төрмандах 3 дугаар байр хүрэл медаль,

хосын төрөлд М. Цэлмүүн, Б. Төрмандах нар Хүрэл медаль,

тавалсан төрлөөр 4 байр багаараа 3 дугаар байр,

12-14 насны ангилалд ганцаарчилсан эмэгтэй төрөлд Б. Бүжинлхам хүрэл медаль

Гурвалсан төрөл, тавалсан төрөл, Денс бүжгийн төрөл, Стер төрлөөр тус тус бүр хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр цом хүрэл медаль,

Хэнтий аймагт зохиогдсон Олимпын наадмын анхны мөнгө, Дэлхийн аварга шалгаруулах анхны хүрэл медальт МУ-ын Хөдөлмөрийн баатар гавьяат тамирчин далай даян дархан аварга Ж. Мөнхбат агсны нэрэмжит Чөлөөт бөхийн өсвөр үеийн улсын аварга

шалгаруулах тэмцээнд 110 кг жинд Д.Бямба-Эрдэнэ хүрэл медаль, 51 кг жинд А.Бямбажав 60 кг жинд Т.Гүрсоронзонгомбо нар шагналт 5 дугаар байр

Фиде мастер Ч.Хүрэлбаатарын нэрэмжит нээлттэй тэмцээнд 1-р БДС -ийн сурагч спортын дэд мастер Э.Энх-Од 2-р байр

Самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль авч багийн дүнгээр 3-р байр

Монгол улсын заан МУГТ Д.Цэнд-Аюушийн нэрэмжит Жудо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах Ази тивийн нээлттэй тэмцээнээс 1 алт, 5 мөнгө, 4 хүрэл медаль авч багийн дүнгээр 3-р байр

Дорнод аймагт зохион байгуулагдсан Д.Дугаржав агсны нэрэмжит Зүүн бүсийн шатрын тэмцээнд 5 тамирчин оролцсоноос Б. Очирсүх 1-р байр тус тус орлоо.

Аймгийн засаг дарга Ж. Эрдэнэбаатарын ивээл дор зохион байгуулагдсан 2019 оны Шатрын шигшээ тэмцээнд 5 сумын 16 байгууллагын 30 гаруй тамирчид оролцлоо.

Насанд хүрэгчдийн Сагсан бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй 16, эмэгтэй 6 баг нийт 22 багийн 200 гаруй тамирчид оролцсон.

Мөн ахмадын шатрын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 14 байгууллагын 28 тамирчин оролцсон.

Насанд хүрэгчдийн Үндэсний шагай харваан тэмцээнд 8 сум, төвийн 4 баг нийт 12 байгууллагын 96 тамирчин оролцсон. Үүнээс болзол хангасан харваачдаас аймгийн гоц мэргэн цолыг 1, аймгийн хошой мэргэн цолыг 8 харваачид олголоо.

#### Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр:

Албан бус/Насан туршийн боловсрол олгох чиглэлээр нийт 26 төрлийн 58 удаагийн сургалтад 602 иргэнийг хамрууллаа. Дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн эзэмшиж буй танхимын болон хувилбарт сургалтыг тогтмол зохион байгуулж, суурь боловсрол эзэмших 37 суралцагчаас 18-аас дээш насны 22 суралцагчдыг хувилбарт сургалтад хамруулан ажиллалаа. Бага боловсрол эзэмших 36 суралцагчаас 18-аас дээш насны 32 суралцагчийг хувилбарт сургалтад хамруулан ажиллав. Бичиг үсгийн боловсрол эзэмшүүлэх сургалтад 220 суралцагч хувилбарт сургалтаар хамран сургаж байна.

Монголын багш нарын ҮИИ их хуралд 16 төлөөлөгч оролцсон. Боловсрол, соёлын салбарын удирдах ажилтнуудад “Байгууллагын менежмент” сэдэвт сургалт зохион байгуулж 16 сургууль, 24 цэцэрлэг, 15 соёл урлагийн байгууллагын удирдлагууд хамрагдлаа.

Литвийн олон улсын их сургуулийн багш доктор, профессор Maxine Pond гадаад хэлний багш нарт 1,5 өдрийн сургалт, 4 сургуулийн ахлах ангийн 300 гаруй сурагчдад гадаадын их дээд сургууль элсэх боломжийн талаар танилцуулга хийж, сонирхсон багш сурагчдаас TOEFL-ын шалгалт үнэ төлбөргүй авлаа.

ЕБС төгсөгчдийн Монгол хэл бичгийн шалгалтад 315 хүүхэд бүртгэн шалгалт зохион байгуулж, дахин шалгалтад 67 хүүхэд хамрагдсан.

Нийслэлийн 29 дүгээр тусгай сургуулийн багш, сурагчдын сургууль сурталчлах өдөрлөгийн арга хэмжээ 1-р сургууль дээр зохион байгуулагдаж, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, багш сурагчдын урлагийн тоглолт, спортын нөхөрсөг тоглолт, Баруун Урт сумтай танилцах аялал зохион байгууллаа.

Карл Попорын мэтгэлцээний сургалт зохион байгуулагдаж 89 сурагч, 16 багш хамрагдан аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулагдаж 16 баг оролцсон.

Үндэсний бичиг соёлын өдрийн угтаж сурагчдын дунд "Монгол бичгийн тэргүүний уншигч" уралдаан зохион байгуулагдлаа.

СӨБ-ийн “Шувуухай” урлагийн наадам зохион байгуулагдсан.

Данийн үлгэрийн зохиолч Ханс Кристиан Андерсений төрсөн өдөр буюу Олон улсын хүүхдийн номын өдрийг угтаж, Дэлхийн хүүхдийн шилдэг зохиолоор номын үзэсгэлэн гаргаж сурталчилан, энэ өдөр хүүхдийн танхимаар ирж үйлчлүүлж, сэдэвчилсэн үзэсгэлэнтэй танилцсан хүүхдүүдэд үлгэрийн ном бэлэглэх арга хэмжээ зохион байгууллаа.

2019 оныг "УНШЛАГЫГ ДЭМЖИХ" жил болгон зарласантай холбогдуулан Баруун-Урт сумын 11 цэцэрлэгт дүрийн тоглолт болон хуруун хүүхэлдэйн тоглолт, чанга уншлага зохион байгуулсан.

“Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан “Миний мэдэх яруу найрагч” хөрөг, гар зургийн уралдаан, эсээ бичлэгийн уралдаан зарлаж “Монголын нууц товчоо” үзэсгэлэн, “Дэлхийн шилдэг зохиолууд” номын үзэсгэлэн, нутгийн зохиолчдын шинэ номын үзэсгэлэн худалдааг 160 гаруй номоор гаргаж сурталчилсан.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 2, 4-р цэцэрлэгт хүргэлээ.

“Гэгээн Муза” наадмын шилдэг зохиолч, шилдэг найруулагчийн шагналт УГЗ Б.Лхагвасүрэнгийн зохиол “Гэгээн тамлан” эмгэнэлт хөгжимт, драмын жүжиг, Софоколийн “Эдип” сонгодог жүжиг, хүүхдийн “Гахайн ганц тоорой” зэрэг жүжгүүд тоглогдсон.

#### Гэр бүл, хүүхэд залуучууд чиглэлээр:

Сүхбаатар аймгийн хэмжээнд “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн салбар дундын анхдугаар зөвлөгөөн”-ийг 2019.04.03-ны өдөр амжилттай зохион байгуулж АЗДТГ, боловсрол, эрүүл мэнд, сургууль, цэцэрлэг, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, гэр бүлийн зөвлөгчид, цагдаагийн төлөөлөл болсон 400 хүн оролцлоо. Тус зөвлөгөөнд МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын газрын дарга О.Сэлэнгэ, мэргэжилтэн ХЭУБ М.Золдэлгэр, Good neighbors ОУ-ын байгууллагын зөвлөх, доктор Х.Баавгай нар сургагч багшаар ажиллаж МУ-ын төр засгаас Хүүхдийн эрх хамгааллын талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Хүүхдийн эрхийг хангахад үүрэг хүлээгчдийн хариуцлага, Үүрэг хүлээгчид хүүхэд хамгааллын асуудлаар хамтран ажиллах нь, Хүүхдийн эрх хамгааллын асуудлаар салбар дундын зохицуулалтыг хангах, Хүмүүжлийн эерэг арга гэсэн сэдвүүдээр мэдээллийг өгч аймаг, сумын удирдлага, удирдах ажилтнууд нэгдсэн ойлголттой болсон нь уг зөвлөгөөний давуу тал болсон. Албан байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан албан хаагчдыг хүүхдийнх нь төрсөн өдрөөр эцэг эхэд нь хүүхэдтэйгээ хамт цагийг өнгөрүүлэх, 1 өдрийн цалинтай чөлөө олгох санаачлагыг дэмжин хүлээн авч, захирамж шийдвэр гаргаж албажуулахаа илэрхийлсэн юм. Төлөөлөгчдөөс хүүхдийн өмнө үүрэг хүлээгч хэн бүхэнд хандан “Зөвлөмж” гаргасан бөгөөд тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахаар болов.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран хурдан морины унаач хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын мэдээлэл, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Хамгаалагдсан хүүхэд-хариуцлагатай уяач” аймгийн уяачдын анхдугаар зөвлөгөөнийг 4 сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд оролцогчдод аймгийн удирдлагын зүгээс хүүхэд хамгаалал, хурдан морины уралдааны зохион байгуулалтын талаар гарсан шийдвэр, бодлого үйл ажиллагааны тухай мэдээллийг нийт 10 сумын 101 уяачдад мэдээлэл өгч харилцан туршлага судлах ярилцлага өрнүүлж, олон нийтэд хандсан уриалга гаргалаа.

2 жил тутамд нэг удаа зохион байгуулагддаг цэцэрлэгийн насны хүүхдүүдийн “Шувуухай-2019” наадам 04-р сарын 20-ний өдөр Сүхбаатар аймгийн Жаахан шарга хөгжимт жүжгийн театрт амжилттай болж өндөрлөлөө. Наадамд 15 цэцэрлэгийн 310 бяцхан авьяастнууд оролцсон. Уг наадам нь Ардын дуу, гоцлол дуу, гоцлол бүжиг, хамтлаг дуу, хамтлаг бүжиг гэсэн таван төрлөөр явагдан шилдгүүдээ тодрууллаа.

Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр /жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны өдөр/-ийг тохиолдуулан аймгийн “Хайрын сар” аяныг зарлаж, аяны хүрээнд “Миний гэр бүлийн аз жаргал” ил захидал, “Хайр гэрэлтсэн инээмсэглэл” гэрэл зургийн, “Миний гэр бүлийн аз жаргал” гар зургийн, “Хос багана” хослон дуу дуулагчдын уралдаануудыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

“Аз жаргалтай гэр бүл” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн гэрээр айлчлах судалгааны арга зүйг нэвтрүүлэн ажиллаж байна. Судалгааны ажлын хүрээнд 2018 онд



сонгогдсон аймгийн 270 өрхөд айлчлан нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг 04 дүгээр сарын 15-аас 05 сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийж байна.

#### Эрүүл мэндийн чиглэлээр:

Хүн амын дундах БЗДХ, В, С вирусийн илрүүлэг, Явуулын амбулаторийн үзлэг шинжилгээ хийж, эмчлэн, эрүүлжүүлэх "Илрүүлье, Эмчилъе, Сэргийлье" 6 сарын аяны удирдамж, төлөвлөгөө гарган уг аяны хүрээнд БЗДХ/ХДХВ/ДОХ-ын оношлуур худалдан авах хөрөнгө гаргах асуудлыг шийдвэрлэж үзлэгийг эхлүүлээд байна.

Сумдын эмийн эргэлтийн сангийн хүн амд эм зүйн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх, зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, ЭМТ-ийн үйл ажиллагаатай танилцаж БЗДХ, В, С вирусийн илрүүлэг болон Явуулын амбулаторийн үзлэг шинжилгээ хийх бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор Асгат, Баяндэлгэр, Сүхбаатар сумдад ажиллаж зарим тулгамдаж буй асуудлуудыг газар дээр нь шийдэж, ЭМД Сангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллалаа. Мөн эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн хурлыг хийж ЭЭС-ийн ажиллах статусыг өөрчлөх хэлэлцүүлэг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 5 сая төгрөгийн санхүүжилтээр "Үе тэнгийн зөвлөгч", "Илрүүлье, Эмчилъе, Сэргийлье" товхимол дэвтрийн эхийг бэлтгэн 2000 ширхэгийг хэвлүүлэн сургалт сурталчилгаанд ашиглаж эхлээд байна

"Эрүүл шүд- Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, үзлэг оношлогоо, эмчилгээ хийх хувийн хэвшлийн эмнэлгүүдийг сонгон шалгаруулж хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж үйл ажиллагааг эхлүүллээ. Мөн хөтөлбөрийг сурталчлах шторк бэлтгэн ЭМ Төвүүдэд хүргүүллээ.

Швейцарын хөгжлийн агентлаг, Дэлхийн банкаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй "Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд тус аймагт "Өсвөр насны хүүхдүүдийн шүдний өвчлөлийг бууруулахад олон нийтийн оролцоо" төслийг эхлүүлж төсөл хэрэгжүүлэгчдийн гарааны сургалтыг зохион байгууллаа. Мөн төсөл хэрэгжих сумдын ЕБС-ийн 5-12 дугаар ангийн сурагчдын дунд ам хөндийн эрүүл мэндийн үзлэг зохион байгууллаа.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд Амилуулах суурь тусламжийн ажил мэргэжлийн уралдаан зохион байгууллаа.

"Эрүүл мэнд-Эрхэм баян" гүйлтийн арга хэмжээг зохион байгуулж 3 дахь удаагийн гүйлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад давхардсан тоогоор ААНэгж, албан байгууллагуудын 1250 албан хаагч, ажилчид болон иргэд хамрагдлаа.

Орон нутгийн "BBS TV"-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан сурталчилгааны 12 шторк, 3 удаагын мэдээлэл өглөө.

Нийгмийн даатгалын талаарх мэдээллийг гар утсаар авах аппликейшн суулгах аяныг өрнүүлж 3800 иргэний гар утсанд уг аппликейшн суулгасан байна.

АНЭ, Цайрт Минерал ХХК, Баруун-Урт сумын 5-р багийн айл өрхүүдэд Нийгмийн даатгалын "Явуулын үйлчилгээ"-г үзүүллээ.

### **ЗУРГАА.СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭ**

#### Асгат сумын сарын ажлын товч мэдээ:

##### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

Тогтвортой амьжиргаа-3 төсөлтэй хамтран сумын хэмжээнд 4-н багийн Иргэдийн нийтийн хурлыг 4-р сарын 22-24 хооронд зохион байгууллаа. Тус хурлын үеэр 2019 оны эхний улиралд хийсэн ажил болон хийгдэх ажлыг танилцуулан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлыг эрэмбэлүүлэх ажлыг зохион байгууллаа. Мөн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн 8 эмч үзлэг, оношлогоо хийлээ.

Аймгийн засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах иж бүрэн үзлэг сургалтад амжилттай дүгнэгдэж хангалттай үнэлгээг авч ажилласан.

Авто тээврийн үзлэг оношлогоонд сумын хэмжээнд 85 хувьтай хамрагдсан байна.

*Төсөв санхүүгийн чиглэлээр:*

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт сум орон нутагт байгаа албан байгууллагын бүртгүүлсэн болон бүртгүүлээгүй барилга байгууламж, газрыг нэгтгүүлэн ажиллалаа.

Сумын ИТХ хурлаар 2019 оны 03-р сарын 27-ны 03 дугаар тогтоолоор сумын төсөвт тодотгол хийсэн ба 4-р сарын 25-ны байдлаар нийт 23 гүйлгээ хийж, 8891.8 төгрөгний зарцуулалт хийгээд байна.

Сумын хэмжээнд татварын орлого 4-р сарын 25-ны байдлаар нийт 2699,1 төгрөг төвлөрсөн байна.

*Хууль эрх зүйн чиглэлээр:*

Архив, төрийн удирдлага зохион байгуулалтын ажилтай танилцах, шалган зөвлөх зорилготой аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Борхүүгээр ахлуулсан ажлын хэсэг ажиллалаа. Тус ажлын хэсэг архив, албан хэрэг хөтлөлттэй танилцаж, байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн хийх талаар МУЗГ-ын тогтоол, журмын талаар заавар, зөвлөгөө өглөө.

*Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш нар Баруун-Урт сумын 2-р цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцон, ажлын байран дээр туршлагаа түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна.

Багийн өдөрлөгийн үйл ажиллагаанд байгууллагаа танилцуулан, зуны сургалтад хамрагдах хүүхдүүдийг бүртгэлээ.

Ерөнхий боловсролын 2018-2019 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн орж суралцах сурагчдад зориулан "14 Хоногийн хөгжүүлэх" сургалтыг зохион байгуулж 1-р ангид элсэн суралцах сурагчиддаа урилга өгч ажилласан. Нийт 28 сурагч бэлтгэл ангид суралцаж байна.

Улсын төрөлжсөн олимпиадын II даваанд 14 багш, 28 суралцагчдыг хамруулсан бөгөөд хими-биологийн багш Ч.Ариунцэцэг биологийн хичээлийн төрөлд 3-р байр эзэлж, багийн дүнгээр 5-р байранд шалгарсан амжилт гаргалаа.

Швейцарын хөгжлийн агентлаг, дэлхийн банкнаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа "Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл"-ийн 2-р шатны "Өсвөр үеийнхний шүдний өвчлөлийг бууруулахад олон нийтийн оролцоо дэд төсөлд ЕБС дээр хэрэгжиж, 5-9-р ангийн нийт сурагчдад Аман хужир эмнэлгийн хамт олон үзлэг хийн эмчлүүлэх шаардлагатай сурагчдад заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

4-р сарын 17-ны өдөр Соёлын байгууллагын "Нээлттэй хаалганы өдөр"-ийн арга хэмжээг зохион байгуулсан. Уг үйл ажиллагааны хүрээнд соёлын байгууллагын 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, 2019 онын үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулагдах шинэлэг ажил, үйлчилгээний талаар танилцуулж ирдгэдийн санал хүсэлтийг сонслоо. 4-р сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан багийн Иргэдийн нийтийн хуралд нүүдлийн номын сан болон урлаг, уран сайхны үйлчилгээгээр үйлчилээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх журам, аймгийн Засаг даргын 2019 оны 420 дугаар захирамжийн дагуу 4-р сарын 22-ноос 24-ныг дуустал, хөдөөгийн 2 баг, сумын төвд хүн амыг эрт илрүүлэг үзлэг, БЗДХ, ХДХВ, тэмбүү, элэгний В,С илрүүлэх, багцын шинжилгээнд ард иргэдийг хамрууллаа. Эмчийн үзлэгт: 174 иргэн хамрагдаж 15-49 насны 709 хүнээс 660-93% хүн БЗДХ, ХДХВ, тэмбүүгийн шинжилгээнд хамруулснаас хуучин 35, шинээр 1 өөрчлөлттэй хүнийг илрүүлж эмчилгээ хийлээ. Шинээр 2 жирэмсэн, 1 элэгний хавдар илрүүлж, 17 эмэгтэйг умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамрууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд 5-н төсвийн байгууллагын 74 төрийн албан хаагч, иргэдэд ХАБЭАТухай хуулиар сургалт зохион байгууллаа. Мөн аяны удирдамжийн хүрээнд ХАБЭАЗөвлөл, ажилтан томилон ажиллуулах

тухай Хөдөлмөрийн Яамны Сайдын 2015 оны 6 дугаар сарын 22 ний өдрийн А/114 дугаар тушаал, ХАБЭАЗөвлөлийн бүтэц, чиг үүрэг, ажил олгогч нарт зориулсан гарын авлага зэргийг бэлтгэн тарааж, аяны хүрээнд хийсэн ажлын тайлан, ХАБЭАЗөвлөл байгуулсан болон ажилтан томилсон тушаалыг гаргаж ирүүлэх талаар мэдэгдэл өгч ажиллалаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрийг иргэдэд зарлан, мэдээлэл өгснөөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 1 иргэн төсөл өгснийг хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэн, тус иргэнийг аж ахуй эрхлэх 5 хоногийн сургалтад хамруулсан, ОНОНТҮүйлчилгээний төсөлд ахмад настны 1 бүлгийн төслийн материал хүлээн аваад байна.

*ХАА, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

Асгат сумын Засаг даргын А/31 дүгээр захирамжийн дагуу сумын ойр орчмын 126 малын сэг зэм, 2,7тн ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт булж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлээ. Мөн багийн ИНХ-ын үеэр аймгийн мал эмнэлгийн газрын халдвартын эмч Ж.Сундуй малын эрүүл мэндийн тухай хууль, орон нутагт гарч байгаа өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар малчид, иргэдэд мэдээлэл хийсэн. Аймгийн мал эмнэлгийн ажлын хэсэг хувийн мал эмнэлгийн малын эмчийн стандартын анхан шатны үзлэг хийж, зөвлөмж өгч, өөрийн хариуцсан өрхтэй гурвалсан гэрээ хийлээ. Мөн эмч нараас угаалгад оруулах өрх, малын тоо, туулга хийлгэх мал, өрхийн судалгааг авч эмийн бодисыг нийлүүлэх ажил хийгдэж байна.

Байгаль орчны тэмдэглэлт “Дэлхийн усны”, “Ойн”, “Цаг уурын” өдрүүдийг угтаж сумын ИТХ, ЗДТГазартай хамтарч “Усны зохистой хэрэглээ” цаашид авах арга хэмжээ сэдэвт сургалтыг албан байгууллага аж ахуйн дарга эрхлэгч иргэдийн төлөөлөн оролцсон 30 иргэнд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэг дээр “Цэвэр ус ба ундны усны сав” сэдэвт мэдээлэл хийж иргэдэд тараах материал өгч байгаль орчны багц хуулиар хууль эрх зүйн сурталчилгаа хийж ажилласан

Хаврын хуурайшилттай үед 4 багийн засаг даргаар дамжуулан “Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагын дэвтэр”, түймрийн сэрэмжлүүлэг, танилцуулга бэлтгэж айл өрхүүдэд хүргүүлж мотоцикль, машин техниктэй иргэдэд яндангийн оч баригч, техникийн бүрэн, бүтэн байдлыг хангаж сонор сэрэмжтэй хөдөлгөөнд оролцож байхыг анхааруулж санамж өгч ажиллалаа. Мөн айл өрхүүдэд үнсээ ил задгай асгахгүй байнгын таглаатай саванд хийж хэвшихыг анхааруулж, багуудын 317 айл өрх, 634 иргэн, 9 аж ахуйн нэгж бүрээр гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан.

Баяндэлгэр сумын сарын ажлын товч мэдээ:

*Төрийн удирдлагын чиглэлээр:*

Түвшинширээ суманд зохион байгуулагдсан аймгийн ИТХ, сумдын ИТХ-ын “Туршлага солилцох уулзалт, сургалт, нөхөрсөг спорт”-ын тэмцээнд ИТХ-ын төлөөлөгч нарын хамт амжилттай оролцлоо.

Сумын засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн А/44 тоот захирамжаар хаврын ээлжит цэрэг татлагыг явуулж, 18-25 насны 94 эрчүүд үзлэгт хамрагдлаа.

4 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн ГХБХБГазраас мэргэжилтэн, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, газрын даамал, нутгийн иргэдтэй хамтран хилийн маргаантай газруудын солбилцолуудыг тодоройллоо.

*Төсөв санхүүгийн чиглэлээр:*

Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн байршууллаа. Статистикийн байгууллагад сарын мэдээг бүрэн дамжуулсан.

Ахмадын өргөөний барилгын ажлын явц, автомат худгийн хамгаалалтын бүс байгуулах хөрөнгийг шийдэж материалыг Улаанбаатар хотоос татах худгийн засварын ажилд хяналт тавьж ажиллаж байна.

### *Хууль, эрх зүйн чиглэлээр:*

Хөдөөгийн багийн Засаг дарга нар малчдаар явж цаг үеийн асуудлаар мэдээ мэдээлэл хийж санал бодлоо солилцож ажиллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс төрийн албаны тухай хуулийн талаарх журмын танилцуулга, хууль зүйн хэлтсээс бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг танилцуулж албан хаагчдад арга зүйн зөвлөгөө, сургалтыг зохион байгууллаа.

### *Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Монголын багш нарын 7-р их хуралд төлөөлөгчөөр оролцсон багш Ж.Бадамханд ЕБС, Цэцэрлэгийн багш нарт хурлаас гарсан шийдвэр, уриалга, Засгийн газрын тогтоол, хурлын үйл ажиллагааны талаар мэдээлэл хийлээ.

“Сайн хичээл” үйл ажиллагааг 4-р сарын 18-23-ны өдрүүдэд цэцэрлэгийн багш нарын дунд зохион байгуулж, туслах багш нараас Ц.Алтанцэцэг, И.Ундрах, А.Гантуяа, бүлгийн багш нараас П.Алтанцэцэг, Д.Хишигдүүрэн, Д.Оюунцэцэг нар бусдыгаа манлайллаа.

Урлаг, соёлын 7 үйл ажиллагаа явагдаж давхардсан тоогоор 1200 орчим хүн хамрагдлаа. Үүнд 04 дүгээр сарын 01-нд Б.Амартүвшин ламын эмчилгээний зардалд зориулсан “Сэтгэлийн бэлэг” хандивын тоглолтыг зохион байгуулж тоглолтын орлого 650.000 төгрөгийг хандив өргөсөн, 04-нд МУСТА Н.Баасандорж, Б.Батболд нарын “Морин сүлдтэй Монгол” тоглолт, 15-нд Хилийн Цэргийн 0184-р ангийн хөгжимчин Мандухай, Отгонцэцэг нарын “Сэтгэлээс урсах аялгуу” тоглолт, АН-ын 30 жилийн цэнгүүн зэрэг үйл ажиллагаанд хөгжим техник хэрэгслээр хангаж хамтран ажиллалаа. Номын сан тухайн сард 73 хүнд гэрээр болон танхимаар 238ш ном олгож, уншигчдад карт нээжлээ. Мөн ЕБС-ийн бага ангийн сурагчид, ахмадуудын дунд “Эмээ өвөөтэйгээ хамт уншъя” уншлагын цагийг зохион явуулж сурагчдад ном уншихын ач холбогдол, гар утас дэлгэцийн хор хөнөөлийн тухай мэдээлэл хийлээ.

Монголын бүжгийн холбооноос мэргэжлийн багш нар ирж Нийтийн цэнгээнт болон спорт 16 бүжгийн сургалтыг 25-наас зохион байгуулж байна.

Ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үдшийн цэнгүүний үйл ажиллагааг нийт 5 удаа зохион байгууллаа.

### *Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

Цайрт минерал ХХК-ны хөрөнгө оруулалтаар нэгдсэн хогийг цэгийн цэгцлэх ажил эхлээд байна. Мөн бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж, 21-н албан байгууллага, аж ахуйн нэгж, 450 гаруй айл, өрхүүд хамрагдаж 40 гаруй тонн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн ажиллалаа. Мөн нохой устгалын ажлыг зохион байгуулж 70 нохой устгалаа.

Мал эмнэлгийн үржлийн нэгжийн судалгааг гаргаж аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн ба мал төллөлт, төл бойжилтын мэдээг хөдөө аж ахуйн газарт долоо хоног бүрийн 3 дах өдөр гаргаж хүргүүлсэн. 12 малчин өрхөөс малчин тамганы захиалга авч малчдад тамгыг олгоод байна.

### Баруун-Урт сумын сарын ажлын товч мэдээ:

Архив бичиг хэргийн улсын үзлэгтэй холбоотой өөрийн харьяаны төсөвт байгууллагуудад архив бичиг хэрэг хөтлөлтийн сургалтыг тамгын газрын архив бичиг хэргийн мэргэжилтэн, сумын ИТХ-ын архив, бичиг хэргийн ажилтантай хамтран зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулан, хяналтад авч ажиллаж байна.

Хууль эрх зүй мэдлэг сорих тестийг ажилтан, албан хаагчдаас авсан. Нийт 40 албан хаагч хамрагдсан бөгөөд сорилын дүнг албан хаагчдад танилцуулсан.

### *Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Улсын сэтгэх чадварын олимпиадын 2-ын давааг сумын Засаг даргын ивээл дор 6 дахь жилдээ зохион байгууллаа. Олимпиадад 16 төрлөөр 1009 хүүхэд багачууд, насанд хүрэгч, багш нар оролцож оюун ухаанаа уралдууллаа.

Энэ жилийн олимпиадын онцлог 4, 5 насны хүүхдүүдийн олимпиадын бодлогын гүйцэтгэлийн дундаж 80%, 1-5-р ангийн хүүхдүүдийн олимпиадын бодлогын гүйцэтгэлийн дундаж 70%-тай байгаа нь оролцогч хүүхдүүдийн чансаа бэлтгэсэн багш нарын ур чадвар өндөр байгааг харуулж байлаа.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар сумын “Боловсролын хөгжлийн 2019-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан. Мөн сумын ИТХ-ын Эрүүл мэнд, Боловсролын салбар хороотой хамтран ажиллах 2019 оны төлөвлөгөөг гаргалаа.

Хөдөлгөөн эрүүл мэнд уриан дор зохион байгуулагдаж буй бүх нийтийн гүйлтийг аймгийн Мал эмнэлэг, 1-р Бүрэн дунд сургууль, Мэргэжлийн хяналтын газруудтай хамтран зохион байгуулж витаминжуулалт хийсэн.

Баруун-Урт сумын 5, 9-р багийн ажлын алба болон “Фокус цахим телевиз”-ийн хамтарсан мэдээллийн цаг лайв нэвтрүүлгийн 2 дахь дугаарт ЭМГ-ын хоол тэжээл хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Э.Сувд-Эрдэнэ оролцож “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” сэдвээр иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа. Тус лайвыг 2142 иргэн үзэж давсны асуудлаар мэдээлэл авч ойлголтоо нэмэгдүүлсэн байна.

1,3,4,5,7,9-р багууд сард 1 удаа заалны цаг авч, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлээд байна.

3,4-р багийн 25 иргэнийг бие бялдрын сорилд хамруулаад байна.

Баруун-Урт сумын 5-р багийн иргэн, “Дөрвөн гэгээн эрдэнэ хоршоо”-ны захирал Б.Гөлөгсайханы гэр бүл, ажил амьдралын тухай өгүүлсэн “Амьдралын амт нэвтрүүлэг”-ийг 04 дүгээр сарын 19-ны өдөр орон нутгийн BBS телевизтэй хамтран бэлтгэж иргэдэд хүргэж байна.

9 багийн фэйсбүүк хуудсыг тогтмол ажиллуулж, цаг үеийн шаардлагатай мэдээллийг тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтанд өгч ажиллаж байна.

10 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран ААВ ЭЭЖ БИ бүтээлийн уралдааныг зохион байгуулж, ирүүлсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа. Нийт 102 хүүхэд, эцэг эхтэйгээ хийсэн бүтээлээ ирүүлж анги хамт олноо идэвхитэй хамруулсан нэг багш, эцэг эхтэйгээ хийсэн бүтээлээс шагналт байранд 4 бүтээлийг шалгаруулсан. Мөн үзэсгэлэнгийн үеэр спорт өрөлтийн тэмцээнийг зохион байгуулж эцэг эхчүүдээ идэвхижүүлэн ажиллалаа.

Аз жаргалын дархлаа үйл ажиллагааг ЕБСургуулийн 11 ангид

1. Эрх зүйн дархлаа
2. Эрүүл мэндийн дархлаа,
3. Оюуны дархлаа
4. Эерэг хандлагын дархлаа
5. Аюулгүй байдлын дархлааны талаарх мэдээллийг “Сүхбаатар тохижилт, үйлчилгээ ОНӨҮГазар”, “ЭМГазар”, өмгөөлөгч Ж.Дэлгэрхишиг, аймгийн нийтийн номын сан, Сүхбаатар аймгийн онцгой байдлын газартай хамтран өгсөн.

Аз жаргалтай гэр бүл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Оюуны чадвар төвийн захирал, коуч Г.Мөнгөн урьж “Аз жаргалтай гэр бүл” лекцэнд 400 гаруй иргэдэд хамрагдаа. Мөн ДБЭХС ТӨХК-ний Сүхбаатар аймаг дахь салбар, Баруун-Урт сумын ЗДТГазрын нийт 78 албан хаагчид харилцаа, хандлага, хувийн санхүүгийн талаарх мэдээлэл өгсөн.

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Тайлант сарын байдлаар дараах халамжийн үйлчилгээг үзүүлээд байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу 29 ахмад настан хөнгөлөлтөд хамрагдаж, 9952900 төгрөгний санхүүжилт зарцуулагдсан.

ХЭБ-ийн үйлчилгээ авч байгаа 2,4,6-р багийн нийт 173 өрхөд бичилт хийн иргэний үнэмлэхний хугацаа дууссан 2 болон төрсний гэрчилгээний лавлагааны 1 хуулбарыг аван хувийн хэргийн баяжилтыг цаг тухай бүрт хийж байна. Хуулийн дагуу 4 хөгжлийн

бэрхшээлтэй иргэн, 1 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөнгөлөлтөд хамрагдаж 1776000 төгрөгний санхүүжилт зарцуулагдсан байна.

Цалинтай ээж” хөтөлбөрийн 1021 эхийн хувийн хэргийг программд хүн тус бүрээр нь тулгалтыг хийж, нийгмийн даатгал төлөгдсөн болон ажилд орсон 28 эхчүүдийн үйлчилгээг зогсоож, шинээр 42 иргэний хувийн хэрэг нээн баталгаажуулаад байна

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

Баруун-Урт сумын 8 дугаар багийн ажлын алба, Мал эмнэлгийн тасгийн дарга Ц.Энхбаатар, Өрхийн эмч Б.Шижир-Эрдэнэ нар 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 20-ны өдрүүдэд Еншөөв, Суурин худаг, Бортын хоолой, Жонш, Наран сарангийн тал, Баян уул, Зүрхийн хоолой, Баян-Өлзийт зэрэг газруудад нутаглаж буй 30 гаруй малчин өрхөөр орж хаваржилтын нөхцөл байдалтай танилцаж, сум орон нутгаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээлэл хүргэж, гал түймрийн аюулаас сэрэмжлүүлэх болон мал эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаа ба малчдын эрх, үүргийн талаарх мэдээлэл бүхий тараах материалыг малчдад хүргэсэн. Тус газруудад ажиллах явцад өвөл цас ороогүйн улмаас хаваржилт хүндэрч байгааг малчид хэлж байлаа. Багийн ажлын алба хөдөөгийн малчдаар үргэлжлүүлэн ажиллана.

Канад сангаас зарласан төслийн уралдаанд 8-р багийн ажлын алба “сумын малчин эмэгтэйчүүдийг чадавхижуулах нь” сэдэвт төсөл, 9-р багийн ажлын алба орон нутгийн эмэгтэйчүүдийн манлайлал сэдэвтэй төслийг бичиж явуулсан.

Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэх тендерийг зарлан ажлын хэсэгтэй хамтран техникийн нөхцөлийг бэлтгэн боловсруулалт хийсэн. Одоогоор агро парк, нэг цэгийн үйлчилгээний төвийг засаж сайжруулах тендерийг зарлах ажлыг хийж гүйцэтгэхээр техникийн нөхцөл, зураг төслийг бэлтгэж байна.

"Таван эрдэнэ" малтай хорооллын хогийн нэгдсэн цэгийг цэгцлэх ажлыг 04 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд Цайрт минерал ХХК-тай хамтран том оврын техник, тээврийн хэрэгслийг 5 өдрийн турш дайчлан 3 сая төгрөгний шатахуун зарцуулан хогийн цэгийг цэгцлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Уг ажлын хүрээнд 6,2 га талбайг 5 га талбай болгож түрэлт хийх, хогийн цэгийн гадна талаар 700м урт 1м гүн шуудуу ухах, талбайн дотор талыг цэвэрлэж далан үүсгэх ажлыг хийлээ Мөн иргэдтэй уулзалт зохион байгуулж, хогийн цэгийн гадуур хог хаяхгүй байх, хорооллын эргэн тойронд цэвэрлэгээ тогтмол хийж байхыг зөвлөлөө.

ГХБХБГазар, Засаг дарга, агентлагийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдах газрууд болон иргэдээс ирсэн хүсэлт гомдлыг шийдвэрлэх, цаашид хийх ажлын талаар уулзалт зохион байгууллаа.

Уг уулзалтаар хөгжлийн ерөнхий төлөвлөөд тодотгол хийж аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулж хэлэлцүүлэх, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газруудыг хугацаанд нь олгож дуудлага худалдааг иргэдэд ил тод зохион байгуулах зэрэг асуудлыг ярьж шийдвэрлэсэн.

Баруун-Урт сумын 5, 9 дүгээр багийн иргэдийн ундны усны хүртээмжийг сайжруулах зорилготой шинээр Усан санг байгуулж байна. Тус ажлыг орон нутгийн "Ёст бэйс сервис" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 05 сарын 01-нд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Засгийн газрын 189 дүгээр тогтоолоор нэг удаагийн нийлэг гялгар уутыг импортлох, худалдаалах, хэрэглэхийг хориглосон, аймаг орон нутгийн иргэдийг гялгар уутнаас татгалзаж, даавуун тор хэрэглэх уриалга гаргах даавуун уут, тор үйлдвэрлэгч хувь хүн, иргэдийг сурталчлах зорилготой ""УРАН ЭЭЖ" даавуун тор урлах уралдаан зарлаад байна. ГЯЛГАР УУТГҮЙ СҮХБААТАРЧУУД уриалгыг дэмжин тус уралдаанд идэвхтэй оролцохыг уриалж ажилласан. Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд иргэд олон нийтийн оролцоог хангах, хоггүй цэвэр орчинд амьдрах, зөв хандлагад уриалах зорилго бүхий "ИРГЭДИЙН УХАМСАР-ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН" аяныг 04 сарын 17-ноос 06 дугаар сарын 17-ыг хүртэл хугацаанд эхлүүлээд байна. Аяныг аймгийн ЗДТГазар, БОАЖГазар, МХГазар, Баруун-Урт

сумын ЗДТГазар, Сүхбаатар тохижилт-үйлчилгээ ОНӨААТҮГазар, Буйр нуур мэнэнгийн сав газрын захиргаа хамтран зохион байгуулж байна.

*Төсөв санхүүгийн чиглэлээр:*

4-р сард орон нутгийн болон төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 1,223,435,1 сая төгрөгийн 586 ширхэг мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулан ажиллалаа.

Шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг тогтмол хугацаанд нь байршуулж, харьяа төсөвт байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллалаа.

Төрийн сан 18-н байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хянан хүлээн авч, нэгтгэн сумын төсвийн гүйцэтгэлийн өр авлагын мэдээг хуулийн хугацаанд freebalance программд оруулж ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангаас хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн эргэн төлөлтөд тогтмол хяналт тавин ажиллаж байна. СХС-ийн төсөл сонгон шалгаруулах товыг сумын ИТХурлын ээлжит V дугаар хуралдаанаар оруулж 07 дугаар тогтоолоор батлуулсан. СХС-ийн хяналтын зөвлөл, Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдэд Засгийн газрын 153 дугаар тогтоол болон холбогдох хууль журмын талаар мэдээлэл хийж, Сум хөгжүүлэх сангийн зээлийн үр дүн, сонгон шалгаруулалт, зээл олголт, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад анхаарч, хамтран ажиллах талаар уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан. СХС-ийн төслийн зээл олгох болсонтой холбогдуулан бизнес төслийг хэрэгжүүлэх сонирхогч иргэдэд "Бизнес төслийн мэдлэгийг нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж, төсөл боловсруулах арга зүй, аргачлал Зээлийн батлан даалтын сан, Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилт, төсөл бичихэд анхаарах асуудлын талаар холбогдох мэргэжилтнүүд мэдээлэл зөвлөмж хүргэн ажиллалаа. Сургалтад 1-9 р багийн 50 иргэн оролцож, өөрсдийн сонирхсон асуулт, төсөл бичихэд анхаарах нэн шаардлагатай асуудлын талаарх мэдлэгээ нэмэгдүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих ажлын санал асуулгыг иргэдэд үйлчлэх тасагтайгаа хамтран авч байна. Зууны мэдээ сонин, Tender.gov.mn цахим сайтаар доорх тендерүүдийг зарласан. Үүнд

Баруун-Урт сумын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил 160.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил,

Нэг цэгийн үйлчилгээний засварын ажлын тендер 105.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цай, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр, цэцэрлэгүүдийн хоол хүнсэнд хэрэглэгдэх хүнсний бараа бүтээгдэхүүнийг худалдан авах тендер цахимаар зарлах гэж байгаатай холбогдуулан захиалагч байгууллага, сонирхогч аж ахуй нэгж байгууллагуудад зөвлөмж, мэдээллийг өгч, санал бодлыг хүлээн авч ажиллалаа. 15 байгууллагын Үдийн цай хөтөлбөрт "Хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх" тендерүүд зарлагдан зохион байгуулсан.

2017, 2018 оны Аудитын тайланд тусгасан зөвлөмж, албан шаардлагын хариуг аймгийн Төрийн аудитын газар болон СТСХэлтэст тус тус хүргүүлсэн.

Статистикийн мэдээ тайлан гаргалтад хяналт тавин ажиллаж байна. ХАӨМС ийн мэдээллийн алдаанд 14 удаа тандалт хийж, 111 алдааг холбогдох хүмүүсээр засуулж ажилласан.

Дарьганга сумын сарын ажлын товч мэдээ:

*Төрийн удирдлагын чиглэлээр:*

ИТХ-ийн Тэргүүлэгчдийн хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 22 нд зохион байгуулж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. Амьжиргааг дэмжих 28 өрхийн жагсаалт батлах тухай

2. Хамтарсан баг шинэчлэн байгуулах тухай
3. Алдарт эхийн 2 дугаар зэргийн одонд тодорхойлох тухай
4. Санал дэмжих тухай

Уг хурлаар нийт 11 эхийг Алдарт –Эхийн 2 дугаар зэргийн одонд тодорхойлж хуулийн хугацаанд холбогдох байгууллага руу хүргүүлэн ажилласан.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурлыг 2019.04.17 нд хийж, 2018 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн тайлан, сангийн зарцуулалт, 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг баталлаа.

Сумын Засаг даргын А/24 дүгээр захирамжаар Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын сумын комиссыг орлогч даргаар ахлуулан 19 хүний бүрэлдэхүүнтэй, түр товчоог 12 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилон төлөвлөгөө, удирдамжийн дагуу ажиллаж, мэдээ тайланг Статистикийн хэлтэст хүргүүллээ.

Монгол улсын Засгийн газрын 32 дугаар тогтоолоор батлагдсан биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын А/25 дугаар захирамжаар 1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдэж “Хөдөлгөөн эрүүл мэнд нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулан, бямба гараг бүрийн 08 цагаас гүйлт, гимнастик хийж хэвшсэн ба 80-100-аад хүн хамрагдаж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллаж байна.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар багийн иргэдэд санал асуулга зохион байгуулах зорилго бүхий ажлын хэсгийг 4-н багийн засаг дарга нараар ахлуулан 04 дүгээр 08-наас 7 хоног ажиллууллаа.

Хүн амын хөдөлгөөний байршлын үнэлгээг сумын хэмжээнд гарган, аймгийн Онцгой байдлын газарт хүргүүллээ.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу байгууллагын албан хаагчдын ажлын байрны дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг сумын Засаг даргын шийдвэрээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Сумын хөгжлийн индексийг [ldi.nda.gov.mn](http://ldi.nda.gov.mn) сайтад орж нэгтгэлээ.

04 дүгээр сарын 13-нд сумын бүх төрийн байгууллагуудын удирдах ажилтан, архив, бичиг хэргийн эрхлэгч нарт архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх дадлага сургалтыг зохион байгууллаа.

04 дүгээр сарын 17-нд сумын Цагдаагийн хэсгээс Монгол улсын Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн сургалт, сурталчилгааг бүх албан байгууллагад хийлээ.

Аймгийн ТЗУХ-т сумын бүх төрийн байгууллагын “Хүний нөөцийн судалгаа”-г дахин гаргаж файлаар болон цаасаар хүргүүлсэн.

*Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

ЕБС-ийн багш, сурагчид нь Сүхбаатар аймагт жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг төрөлжсөн олимпиадад нэгдсэн дүнгээр 3 дугаар байрт шалгарлаа.

Багш, ажилчдын улирлын ажлыг дүгнэх, үнэлэх зорилгоор тайлангийн хурлыг зохион байгуулж, 10 үзүүлэлтээр ажлыг дүгнэн, 25 багшид 16-60 хувийн улирлын урамшуулал олголоо.

“Угийн бичиг хөтлөлтийн талаар” төрийн албан хаагчдад танхимын сургалтыг сумын Албан бус, насан туршийн боловсрол төвийн багш, Соёлын төв хамтран зохион байгууллаа.



“Дэлхийн номын өдөр”-ийг угтаж тусгай төлөвлөгөө удирдамжийн дагуу 04 дүгээр сарын 17-нд “Номтой нөхөрлөх нь хамгийн чухал” ярилцлага, мэдээллийг сумын Соёлын төвийн номын санч зохион байгуулж 40 гаруй хүн оролцлоо.

Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлэгчид, сургуулийн сурагчид, иргэдэд хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээлэл хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 40 сая төгрөгийн үнэ бүхий МОБАЙЛ технологийн иж бүрэн аппаратаар хангасан ба уг аппаратаар иргэдэд үйлчилгээ үзүүлсэн.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд мал маллах сонирхолтой аймаг, сум, төв суурин газарт амьдарч буй мал маллаж байсан болон шинээр мал маллах сонирхолтой 18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй гишүүнтэй өрх, гэрээт малчин авч ажиллуулах сонирхолтой малчин өрхийг 05 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон сумын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн бүртгэж байна.

Сургалт, сурталчилгааны багт нийгмийн даатгалын байцаагч, хөдөлмөр халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн нар оролцон ажиллаж, мэргэжлийн чиглэлээр мэдээлэл хийж, I II III IV багийн нийт 204 өрхийн иргэдтэй уулзаж, гарын авлага тараалаа.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” сарын аяны хүрээнд удирдамж гарган, төрийн байгууллага аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулж, “Албан байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн бүтэц, чиг үүрэг”, “ажил олгогчдод зориулсан гарын авлага” зэрэг материалыг тархаалаа.

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарих ажлыг 5 мал эмнэлэг гүйцэтгэн зохион байгуулж нийтдээ 167550 толгой малд тарилга хийсэн бөгөөд үүнээс үхэр 17814, хонь 95031, ямаа 54705-ыг хамрууллаа.

Иргэд, малчдад малаа даатгуулахын ач холбогдлыг тайлбарлан таниулж, сурталчилж ажиллахын зэрэгцээ 11 малчин өрх 4-5 сая төгрөгөөр малаа даатгууллаа.

Сумын I, II-р багийн малд шинжилгээ хийлгэхэд яс зөөлрөх өвчин гэсэн онош тодорсны дагуу ХХАА-н яам, мал эмнэлгийн Ерөнхий газраас малын эмч Эрхэмбаатараар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж 2 хоног ажиллаж 1-р багийн 8 өрхийн 18 үхрээс цусны шинжилгээ авахаар дээж авч, лабораторид хүргүүлээд байна.

Сумын 2 дугаар багийн хоёр малчин өрхийн ишиг олноор үхлээ гэсэн дуудлагын дагуу малын эмч үзлэг хийж, 15 ишгэнд задлан шинжилгээ хийхэд уургийн зангирал, үс хялгас идсэнээс ходоод гэдсэнд түгжрэл үүссэн байсныг малчдад газар дээр нь үзүүлж, тэдэнд хот хороогоо цэвэрлэж байх талаар зөвлөв.

Аймгийн Аудитын газраас 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг суманд ажиллаж, 2015-2019 оны газар олголтын шийдвэрт хяналт шинжилгээ хийж, 2018-2019 оны сумын Засаг даргын 35 захирамжийг эх хувиас нь хуулбарлан авсан.

“Байгаль хамгаалахад Эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэгт сургалтыг 04 дүгээр сарын 15-нд сумын Байгалийн цогцолборт газрын захиргаа хариуцан зохион байгуулж, хөдөөгийн 4-н багийн төлөөлөл 95 хүн хамрагдлаа.

04 дүгээр сарын 17-нд БОАЖЯ-ны Ойн бодлогын газрын дарга Г.Ариунсанаа, ахлах мэргэжилтэн Ц.Чулуунбаатар, ОБЕГ-ын ахлах мэргэжилтэн хошууч Соронзонболд нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй баг суманд ажиллаж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах талаар гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нөхцөл байдалд дүгнэлт хийж, 9 заалт бүхий зөвлөмжийг өгсөн.

Хээрийн болон ахуйн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлэлцүүлэгт сургалтаар болон объектод очиж гарын авлага тархах, иргэд олон нийт ихээр цугларсан газарт очиж мэдээлэл хийх зэрэг арга хэлбэрээр сурталчилгааг тогтмол хийж байна.

“Дарьганга Тохижилт Үйлчилгээ” ОНӨААТҮГ 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хогийн нэгдсэн цэгийн дотор талын хогийг түрж дээшлүүлэх, гадна талын хогийг овоолж

зөөх, мал нядалгааны цэгийн болон зүүн гол, гол орчмоос элс авч байсан нүх, наадмын талбай, нийтийн эзэмшлийн газрын хогийг түрж ачиж, зөөх, булах ажлыг 8 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ. Мөн сумын төвийн золбин нохой устгах ажлыг эхлүүлж өнөөдрийн байдлаар 65 нохой устгаж, зохих арга хэмжээг авч байна.

Аялагч, иргэдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан 04 дүгээр сарын 22-нд Шилийн богдын царанд түймэр гарч, их хэмжээний газар шатсан бөгөөд тухайн үед “Хөх-Уул андууд” жуулчны баазын эзний ахалсан “Түймрийн 2 дугаар” бүлгийн 12 гишүүн шуурхай унтраах арга хэмжээ авч ажиллалаа.

#### Мөнххаан сумын сарын ажлын товч мэдээ:

##### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

Сар бүр график төлөвлөгөөг гаргаж хариуцсан ажилтнуудад ажил үүргийн хуваарийг танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засаг даргын шуурхай хурлыг 2 удаа зохион байгуулж, байгууллагын дарга нарт үүрэг чиглэл өгсөн ба сар бүрийн 25 ны дотор тухайн сард хийсэн ажлын тайланг Засаг дарга хүлээн авч гүйцэтгэлд хяналт хийн ажиллаж байна.

2019 оныг МУ-ын Засгийн газраас “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил “ болгон зарласантай холбогдуулан ЗДТГ-аас Түмэнд ойрхон төрийн үйлчилгээ уриаг дэвшүүлсэн ба төрийн үйлчилгээний талаарх танилцуулга, гарын авлагыг бүхий хавтсыг айл өрхүүдээр ажлын хэсэг гарган танилцуулан аялууллаа. Энэ арга хэмжээнд Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Тамгын газрын мэргэжилтэн албан хаагчид нийт 187 айл өрх, 18 аж ахуйн нэгж, 3 төсөвт байгууллагуудын 450 гаруй иргэн, төрийн албан хаагчдад мэдээ мэдээллийг хүргэн ажиллалаа. Тус хавтсаар дамжуулан Тамгын газрын бүтэц бүрэлдэхүүн, албан хаагчдын утас, Тамгын газрын мэдээлэл хүлээн авах суурин утас /83177070/, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний бүрдүүлэх материал /халамж, газар, нийгмийн даатгал, татвар, улсын бүртгэл/-ыг танилцуулж, ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх ажлын санал, “Надад нэг санал байна” иргэдийн саналыг авч, 2018 оны үйл ажиллагааны тайлан болон 2019 онд хийгдэх ажлын талаар мэдээлэл хүргэж, эрүүл мэндийн үзлэгийг гэрээр үзүүлж ажиллалаа.

Мөн архивын улсын үзлэг шалгалтад бэлтгэж комисс томилж, төлөвлөгөө гарган, төсөвт байгууллагууд бичиг баримтыг хавтаслаж, хаяглаж цэгцэлж архивын өрөөг тохижуулсан.

##### *Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

Сумын засаг даргын 2019 оны А/30 тоот захирамжаар албан байгууллага, айл өрхүүдийн цэвэрлэгээг хийлгэхэд 483 айл өрхүүд хамрагдлаа. Үүнд 120л түлш буюу 300000 төгрөгийн ШТМатериал, 108 тн хог хаягдлыг зайлууллаа.

Цэнгэг усны нөөц Байгаль хамгаалах төвөөс зарласан “Нэг удаагийн нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео бичлэгийн уралдаан зарласан ба тус сумын “Экологич” Эко клубийн бүтээл шалгарч аймгаа төлөөлөн 4-р сарын 5-11-ний өдрүүдэд Олон улсын хүүхдийн найрамдал зусланд амрах, сургалт хөтөлбөрт 9а ангийн 7-н сурагч Байгаль хамгаалагч З. Гэрэлчимэг нар хамрагдлаа.

04 сард зохиогдсон багуудын иргэдийн нийтийн хуралд Байгаль орчин, ХАА тасаг, НД, Татвар, Халамж, Газар, МЭТасгууд мэдээлэл хийж гарын авлага тараан мөн хуурайшилтын улирал болж байгаатай холбогдуулан сэрэмжлүүлэг, санамж бичиг тараах ажлыг хийлээ. 04-р сарын 10, 11-нд 1-р БЗДарга Б. Эрдэнэбат, 1-р БИНХДарга Ч. Ууганбаяр, Цагдаагийн тасгийн дарга Б. Бат-эрдэнэ нарын хамт Хажуу худагт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан жоншны уурхайд хяналт шалгалт хийж үйл ажиллагааг зогсоосон. 3-р багийн иргэн П. Нүрзэд, Д. Амгалан 4-р багийн иргэн П. Эрдэнэбаатар, 2-р багийн иргэн Н. Эрдэнэбаяр нарт хугацаатай албан шаардлага өгч гаднах орчны хог цэвэрлэгээ болон малын хэвтэр хогийг цэвэрлэж зөөж гаднах орчноо цэвэр байлгах талаар үүрэг чиглэл өгөн ажиллалаа.

*Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Төрөлжсөн хичээлүүдийн олимпиадын 2-ын даваа буюу аймгийн аварга шалгаруулах олимпиадад 13 төрлөөр 29 багш, 64 сурагч сум, сургуулиа төлөөлөн оролцож нийт 16 сургуулиас багийн дүнгээр 5-р байр эзэллээ.

1-р улиралд номын сангийн олон нийтийн ажил 3 удаа, нийт уншлаганд 125 ном гарч 230 хүүхэд 56 насанд хүрэгчдэд номоор үйлчиллээ.

Соёл урлагын 4 нэр төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж 450 гаруй үйлчлүүлэгчдийг үйл ажиллагаандаа хамруулсан. ЕБС-тай хамтран “Өв соёлын наадам”-ыг зохион байгууллаа. Сумын ахмадын хороотой хамтран өдөр бүр цэнгээнт 2 бүжиг, 2 дууг ахмадуудад зааж байна.

Эрүүл мэндийн төвөөр 4-р сарын 25-ны байдлаар 38 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 29 насанд хүрэгчид, 9 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн байна. Амбулаторийн үзлэг 564 хийгдсэнээс 155 урьдчилан сэргийлэх үзлэг байна. Түргэн тусламжийн дуудлага 88 ирснээс нь алсын дуудлага 23, ойрын дуудлага 65 ирсэн байна.

Олон улсын сувилагчдын баярыг тохиолдуулан сувилагч нарын дунд ажил сайжруулах 14 хоногийн аян зохион байгуулж, хичээл заах зэрэг уралдаан зохиож сувилагч Б.Будсүрэн түрүүлж цалингийн 20%-иар шагнуулсан. Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулж байгаа “Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо” уриан дор явагдаж буй сувилагч нэг өдөр арга хэмжээнд ЭМНА, ахлах сувилагч, сувилагч 3 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож “Хуванцар савны хэрэглээ” сэдвээр видео бичлэг бэлдэж ЭМГ-ын цахим хуудсанд байршуулсан.

Шинээр баригдаж байгаа Соёлын төвийн байрилгад ажиллаж байгаа ажилчдад ХАБЭА-н талаар ХАБЭА-н хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч ажиллалаа. ААНэгж байгууллагууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг мөрдлөг болгож ажиллахыг зөвлөн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоолыг танилцуулж гарын үсэг зуруулан ажиллалаа.

Наран сумын сарын ажлын товч мэдээ:

*Төрийн удирдлагын чиглэлээр:*

Сумын Засаг дарга болон Тамгын газрын холбогдох албан тушаалтанд хандаж 56 өргөдөл гомдол ирүүлж, 51 өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэгдэх хугацаа болоогүй 4 шийдвэрлэлт 91,07 хувьтай байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗДТГ-ын албан хаагчдад болон албан байгууллагын бичиг хэргийн ажилтан нарт “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-аар сургалт зохион байгуулж, журмын дагуу товъёог боловсруулан ЗДТГ-ын 21 албан хаагчийн хувийн хэргийг шинэчиллээ.

04 сарын 22-ны Мэдээллийн цагаар Засаг дарга 2019 оны 1 дүгээр улиралд хийсэн ажлын тайлан иргэддээ танилцууллаа.

ЗДТГ-ын албан хаагчийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Долоо хоног бүрийн 3 дах өдрийн 15<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийг спортоор хичээллэх цаг болгож удирдамж боловсруулан батлууллаа.

Орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнд МУ-ын Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын 15 үүрэг даалгавар, 24 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Засаг даргын зөвлөлөөр албан байгууллагын дарга,эрхлэгч нарын 1-р улиралд хийсэн ажлын тайланг хэлэлцлээ.

ЗДТГ-ын ёс зүйн хорооноос санаачлан хамт олноороо нэгдсэн ажил хэрэгч хувцастай болох ажлын зохион байгууллаа.

04 дүгээр сарын 11-16-ны өдрүүдэд сум, багийн Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтэн нар иргэдтэй уулзаж, санаа бодлыг сонсож, ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал авч, шаардлагатай мэдээллийг өгч ажиллалаа.

04 сарын 17-20-ны өдрүүдэд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумтай ЗДТГ-ын албан хаагчид туршлага судлах уулзалтыг зохион байгууллаа.

*Санхүү, төрийн сангийн чиглэлээр:*

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сүхбаатар аймаг дахь төрийн Аудитын албанд хуулийн хугацаанд аудит хийлгэн зөрчилгүй санал дүгнэлт авч ажиллалаа.

Төрийн болон орон нутгийн байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн барилга байгууламж, газар гэх мэт үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж дууссан. Дахин үнэлгээний нэгтгэлийг Оорон нутгийн өмчийн газарт хүргүүлж, архивын нэгж үүсгэн ажиллалаа. Үнэлгээгээр сумын хэмжээнд 5 байгууллагын 15 барилга, 1 байгууламж, 5 нийтийн эзэмшлийн байгууламж, 8 газрын хамт үнэлгээнд хамрагдаж 8 газар нийт 27440000 төгрөг, 15 барилга 1474538460 төгрөг, 1 байгууламж 40083930 төгрөг, 5 нийтийн эзэмшлийн байгууламж 16730000 төгрөг нийт 1531352390 төгрөгөөр үнэлэгдэн данс бүртгэлд бүрэн тусгагдсан.

*Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого, Байшин орон сууцны 2019 оны тооллогыг чанартай зохион байгуулах зорилгоор хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах, мэдээллийн баяжилтийг эрчимжүүлэх ажлыг сум багийн нийт хүн амын 20 хувийн буюу 332 өрхийн мэдээллийг бүртгэлийн хуудсаар цуглуулж Хүн ам, өрхийн мэдээллийн санд шинэчлэн орууллаа.

“Хамтарсан баг” 1 иргэнээс ирсэн өргөдлийн дагуу хуралдаж тухайн гэр бүлд үнэлгээ хийж гэр бүлийн хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж хяналт тавьж ажиллалаа. Мөн архины хамааралтай өрхийн судалгааг гаргаж “Хамтарсан баг”-ийн гишүүдийг хуваарийн дагуу тухайн гэр бүлд хяналт тавьж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, “Хандлагаа өөрчилж хайр түгээе” сарын аян зарлаж хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэн ажиллалаа.

Эрүүл мэндийн төвөөр 315 үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх-22, идэвхтэй хяналт-52, гэрийн идэвхтэй хяналт -42, холын дуудлага –35, ойрын дуудлага–68, жинэлсэн хүүхдийн тоо-60, хөхний хавдрын урьдчилан сэргийлэх үзлэгт – 33, эсийн шинжилгээ-18 тус тус хамрагдсан байна. Мөн эмч, ажилчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Эхэсийн нүх болон хог хаягдал түр хадгалах байрыг засварласан.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд сумын Засаг Даргын нэрэмжит монгол хэл, математикийн хичээлийн түвшин тогтоох шалгалт авахад математикийн хичээлийн сургуулийн дундаж 47.8%, монгол хэлний хичээлийн дундаж 63.3%, нийт дундаж 55.3%-тай шалгагдсан байна.

Улсын төрөлжсөн олимпиадын 2-н даваанд багш сурагчид амжилттай оролцож 5-7-р байруудыг эзэлж багийн дүнгээр 4-р байрыг эзэллээ.

Цэцэрлэгийн хүүхдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 4-р сард “Тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөн” сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулан, хөгжүүлэх үйл ажиллагааныхаа дагуу мэдлэг боловсролыг олгож байна. Мөн бүлэг бүрт “Номын богц” аялж байгаа бөгөөд “НЭГ ХҮҮХЭД- НЭГ НОМ” аянг давхар өрнүүлээд байна. Бүлгийн багш нар хамтран “Салхинцэцэг, улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх” талаар гарын авлага бэлтгэж, нийт 15 эцэг эхчүүдэд тарааж мэдээлэл хүргэсэн.

Дархлааг дэмжих, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цэцэрлэгийн 106 хүүхдийг 30.000 төгрөгөөр 14 хоног витаминжууллаа. Бага бүлгийн эцэг эхчүүдийн дунд “Та үүнийг мэдэх үү?” сургалт, 2 ээжийг урьж “Урилгат үйл ажиллагаа”-г зохион байгууллаа. Хөгжмийн үйл ажиллагаагаар “Миний дотны найз” дуу, “Baby shark dance” хөгжимт

хөдөлгөөнийг зааж, санал бодол сэтгэгдлээ хуваалцсан. Мөн эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч Дэлгэртуяаг урьж, “Шүдийг зөв угаах, хэрхэн арчлах хамгаалах” талаар сургалт явуулж 13 эцэг эхийг хамрууллаа.

Соёлын төвөөс 4 дүгээр сарын 1-ны инээдмийн баярыг угтан баг, байгууллагуудын дунд “Инээцгээ хүмүүсээ” тэмцээн, дэлхийн номын өдөр, Х.К.Андерсений төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор “Үлгэрийн орноор аялцгаая” дүрийн тоглолт, Нархан Цэцэрлэгийн суралцагч нарт “Чихэртэй уншлага”-ыг зохион байгуулж Монгол ардын сургамжит үлгэр “Ухаант хүүгийн үлгэр”, “Туулай яагаад мах иддэггүй вэ” үлгэрийн дэлгэцээр үзүүллээ. Мөн 2-р багийн иргэн Ч.Энхзулын “Амин үргэлжлэл” анхны бие даасан тоглолт, СТА Мөнгөншагай “Андгайт нутаг”, 0184-р ангийн “Сэтгэлээс урсах аялгуу” тоглолтуудыг хүлээн авлаа.

Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтийн сарын аян зарлагдсантай холбогдуулан ажиллах төлөвлөгөө гаргаж 04 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд иргэдэд мэдэгдэл өгч 11 хүний 11561200 төгрөгийг төвлөрүүллээ.

ХАБЭА-ын сарын аяны хүрээнд зөвлөлийг хуралдуулж 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулсан. Төсөвт байгууллагуудад 04 дүгээр сарын 03-ны өдөр ХАБЭА-ын ажилтан ажиллуулах талаар албан бичиг, гарын авлага хүргүүлж байгууллага бүр нэг ажилтан дээр хавсарган гүйцэтгүүлэхээр боллоо.

04 дүгээр сарын 10, 11, 12-ны өдрүүдэд Гүн худаг багт явж 123 өрхөд хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөр, гэрээт малчин хөтөлбөрийн талаар мэдээлэл хийж, гарын авлага тараалаа.

04 дүгээр сарын 03-ны өдөр Баялаг бүтээгч 7 иргэнд төсөл хөтөлбөр, зээлийн талаар, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн талаар 5 иргэнд мэдээлэл өгч, гарын авлага тараалаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах шалгуур хангасан малчин өрхийн нэрсийг гаргасан.

Шинэ ажлын байр-2, түр ажлын байраар-4 иргэнийг LMISпраграммд бүртгэсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж асаргааны тэтгэмж сунгуулах-2, шинээр асаргаа тогтоолгох 1 иргэний, ОНОТХҮ-ий төсөл хөтөлбөрт хамрагдах 1 бүлгийн асуудлыг хэлэлцсэн.

04 дүгээр сарын 10,11,12-ны өдрүүдэд Гүн худаг багт явж 123 өрхөд нийгмийн халамжийн хуулийн талаар, аймгийн ахмадын амралтын талаар мэдээлэл хийж, асаргаатай 7 иргэдийн асаргаа хэвийн явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж гарын авлага тарааж ажиллалаа.

Амьжиргааг дэмжих 23 өрхөд ОНОТХҮ-ий төслийн талаар мэдээлэл хийж 2 бүлгийн иргэдэд заавар зөвлөгөө өгч төслийг хүлээн авлаа.

Сумын 7 ахмад, зорилтот бүлгийн 3 ахмадын төлбөрийн 50%-ийг “Зорилтот бүлгийн хөгжил хамгааллыг сайжруулах” хамтарсан багийн 2019 оны төсвөөс төлж аймгийн ахмадын амралтад амраасан.

#### *Хөдөө аж ахуйн чиглэлээр:*

3 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Аймагт Хүнс хөдөө аж ахуйн удирдах ажилтан, мэргэжилтний нэгдсэн зөвлөгөөнд болж 2018 оны ажлаараа МЭҮТасаг нь 2-р байрт шалгарсан.

Энэ сард ингэ-16 гүү-32 үнээ-523 эм хонь-18779, эм ямаа-7160 нийт 26510 толгой эх мал төллөсөн.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 8 иргэний 62,1 сая төгрөг төлүүлэх хугацаатай мэдэгдэл өглөө.

“Цэвэрч хот айл, өрх шалгаруулах” уралдааны журмыг боловсруулж Засаг даргаар хянуулж 1, 2 дугаар багийн өрхүүдэд тараах ажлыг зохион байгуулсан.

Усны сав газрын захиргаанд 1-р багаас 1, 2-р багаас 2 нийт 3 гүн өрмийн худаг гаргах захиалга, судалгааг хүргүүллээ.

### *Байгаль орчны чиглэлээр:*

"Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан 8-9-р ангийн сурагчдад "Цэнгэг ус-Тэгш хүртээмж" сургалтыг хийж "Танин мэдэхүйн" АХА тэмцээнийг зохион явууллаа.

Хөдөө аж ахуйн тасаг, багийн засаг дарга нартай хамтран "ЦЭВЭРЧ ХОТ АЙЛ ӨРХ" шалгаруулах 10 сарын аяныг зарлалаа. Уг аяны зорилго нь сумын малчид нийт иргэд хог хаягдалгүй цэвэр орчныг бүрдүүлэн соёлч байдлыг хэвшүүлснээр орчны бохирдлыг арилгаж хүрээлэн буй орчин, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, цэвэрч үзлийг төлөвшүүлэхэд оршино.

1, 2-р багийн айл өрхүүдэд "ХУВАНЦАР УСНЫ САВНААС ТАТГАЛЗЪЯ" уриалгыг дэвшүүлэн модон "Эко усны сав"-ыг танилцуулан 60 өрхөөс захиалга авсан. Мөн суманд үйл ажиллагаа явуулж буй 6 аж ахуй нэгжүүдэд МУ-ын Засгийн газрын 339 дугаар тогтоолоор батлагдсан журмыг танилцуулан "Гялгар уутны хэрэглээг багасгах" иргэдэд гялгар уут тороор үйлчлэхгүй байхыг анхааруулж ажиллалаа.

### Онгон сумын сарын ажлын товч мэдээ:

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, хууль сурталчилан зорилгоор төрийн мэдээллийн цагийг 1 удаа зохион байгууллаа.

МУЗГ-аас 2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний ажил болгон зарласантай холбогдуулан Төрийн үйлчилгээг таны гэрт жил болгон зарлаж төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Соёлын төвөөс соёл, олон нийтийн үйл ажиллагаагааний төлөвлөгөөний дагуу зохион олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 03 сарын 07, 08 ны өдрүүдэд баярын хурал, хүндэтгэлийн тоглолт үдшийн цэнгүүнийг тус тус зохиож, Монгол цэргийн өдрөөр 2-р багийн малчин Б.Золжаргал, Ө.Даваа нар хамтран урлагын тоглолтыг хийлээ. Мөн 3 сарын 15 ны өдөр "Дуулах өдөр" ахмадын дуун цэнгүүнийг 1-р багийн ажлын алба, Ахмадын хороотой хамтран зохион байгууллаа.

Бүх нийтийн спортыг хөгжүүлэх, иргэдийг хичээллүүлэх зорилгоор сумын залуучуудын дунд гар бөмбөгийн тэмцээнийг залуучуудын холбоотой хамтран зохион байгууллаа.

### Сүхбаатар сумын сарын ажлын товч мэдээ:

#### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

Аймгийн Засаг даргын 2019 оны А/123 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын мөн оны А/29 тоот захирамж гарч 04 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Даваа гараг бүрийн 08:00 цагаас шуурхай зөвлөгөөн зохион байгуулж хэвшээд байна. Шуурхай зөвлөгөөнд сумын баг, байгууллагуудын удирдах ажилтнууд болон орон нутгийн салбар хариуцан ажиллаж байгаа мэргэжилтэн, албан хаагчид нийт 32 албан хаагч хамрагдаж байна.

ЗДТГ-аас баг бүрт ажлын хэсэг томилогдож 04 дүгээр сарын 02-ноос 08-ны хооронд баг тойрох ажлыг зохион байгуулсан.

04 дүгээр сарын 05-нд сумын хэмжээнд нэгдсэн хог цэвэрлэгээг зохион байгуулсан.

04 дүгээр сарын 17, 18-нд тээврийн хэрэгслийн хяналт, оношилгоо суманд зохион явагдаж 360 гаруй тээврийн хэрэгсэл хамрагдсан ба хамрагдалт 86 хувьтай.

04 дүгээр сарын 18-нд аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар ажиллаж төрийн албан хаагчид болон иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтанд 170 гаруй иргэд хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/95 дугаар захирамжаар зохион байгуулагдаж байгаа аймгийн Засаг даргын нэрэмжит “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”-ийг 04 дүгээр сарын 18-ны өдөр аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга Онцгой байдлын дэд хурандаа Д.Бат-Эрдэнээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг суманд ажиллаж тус сумын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдал, баримт бичгийн бүрдэлд шалгалт, зөвлөмж өглөө.

04 дүгээр сарын 19-нд ЗДТГ-ын албан хаагчдын 1-р улирлын тайланг сонслоо.

Аймгийн ЗД-ын 2019 оны А185/, Сумын Засаг даргын 2019 оны А/35 дугаар захирамжаар 2019 оны хаврын ээлжит цэрэг татлагын урьдчилсан үзлэгийг 4-р сарын 21-ны өдөр зохион байгууллаа. Цэрэг татлагын урьдчилсан үзлэгээр 18-25 насны 128 залуучуудаас 67 залуучууд орж 32 залуу аймгийн нэгдсэн үзлэгээр орохоор болов.

#### *Төсөв, санхүүгийн чиглэлээр:*

4-р сарын 08-ны өдөр Сүхбаатар аймгийн Төрийн Аудитын газраас 2018 оны ОНХС-ын гүйцэтгэл, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулаа.

2019 оны орон нутгийн төсвийг батлуулж, төсвийн хуваарийг Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

2019 онд БЭМС болон ОНХС-ийн хөрөнгөөр хийх бараа ажил, үйлчилгээний жагсаалтыг батлуулсан.

#### *Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр:*

Хүн ам орон сууцны ээлжит тооллого /2020/, Байшин орон сууцны 2019 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд ХАӨБ-ийн дэвтэр шинэчлэгдсэн тул нийт хүн амын 34,8 хувьд мэдээлэл шинэчлэн, тайлан мэдээг Статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Албан байгууллагын ХАБЭАхуй хариуцсан мэргэжилтэн болон тогооч нар, ААН-ын төлөөлөл, Хайлааст голомт ОНӨТҮГазрын албан хаагчдыг хамруулан 04-р сарын 22-ны өдөр МСҮТ-ын сургагч багш нарын 14 цагийн хичээл бүхий "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй"-н 0,5 кредитийн сургалтыг суманд зохион байгуулж 23 иргэнийг хамруулан СЕРТИФИКАТ олгосон.

#### Түвшинширээ сумын сарын ажлын товч мэдээ:

#### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

2019.04.10-11-ний өдрүүдэд аймгийн ГХБХБГазар, Уулбаян, Баяндэлгэр зэрэг хил залгаа сумдын удирдлагууд, холбогдох мэргэжилтэн, малчдын зэргийг оролцуулан, хилийн цэсийн маргаантай цэгүүдийн тодруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлогын хүрээнд сумын Засаг даргын санаачлагаар Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэн “Хөдөлгөөн- эрүүл мэнд” нийтийн бүжгийн тэмцээнийг зохион байгуулсан байна. Уг тэмцээнд 4 албан байгууллага, ахмадын баг нийт 150 иргэд баг болон оролцсоноос Хүүхдийн цэцэрлэгийн баг хамт олон тэргүүн байр эзэлж цаашид шилжин явах цомыг хүртсэн байна.

#### *Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалл, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:*

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2019-2020 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 6 хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр баталсан. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, ХБИ ажлын байрыг дэмжих хөтөлбөрт төсөл өгсөн 1-р багийн иргэн Б.Батзориг, 3-

р багийн иргэн В.Дамбасүрэн, А.Билэгдэмбэрэл нарын 3 иргэнийг 04-р сарын 09-нээс 4-р сарын 13-ныг дуустал хугацаанд аж ахуй эрхлэх 5 хоногийн сургалтад хамруулсан.

Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2019 оны 03-р сарын 25-ны өдрийн "Эргэн төлөлтийн авлага барагдуулах сарын аян"-ыг тус сумын хүрээнд 2019 оны 03-р сарын 25-наас 2019 оны 04-р сарын 25-ныг хүртэл нэг сарын хугацаанд зарлаж, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг эргэн төлөлтийг барагдуулах, хувиарын дагуу цаг хугацаанд хийлгэх зэрэг ажлыг зохион байгуулан, 04-р сарын 10-ны байдлаар 19 иргэн нийт ХЭДС-д 13,680,000 төгрөгийг төвлөрүүлсэн.

04-р сарын байдлаар Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 3 иргэнд 612,690 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар, "Бүртгэсэн" төлөвтэй 5 иргэдийн мэдээллийг жагсаалтаар гарган 04-р сарын 8-ны дотор өгч WAIS программд баталгаажуулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 33 өрхийн "Хөдөлмөрийн нөхцөл хамаарахгүй иргэд"-ийн тоон мэдээ, судалгаагаар жирэмсэн болон амаржсан-7 иргэн, хүүхэд нь СӨБ-д хамрагдаагүй бол 6 хүртэлх насны хүүхэд асарч буй эх-10 иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асарч байгаа-4 иргэн, Их дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцаж байгаа-4 иргэн, хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан-10 иргэн, малчин-34 иргэн нийт 69 иргэний мэдээлэлийг хувийн хэргээс тулгаж гарган аймгийн ХХҮГ-т гарган хүргүүлсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж уг хурлаар нийт 2 өргөдөлийг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд: Байнгын асаргаа шаардлагатай 2 ахмад настаныг асарч буй 2 иргэнд асаргааны тэтгэмжид сунгалт хийглээ.

10 багш 3 удирдах ажилтан Улаанбаатар хотод БМДИ очиж "Багшийн хөгжил өнөөгийн чиг хандлага" үнэлгээний журам, даалгаврын сан", багшийн хөгжлийн хууль чиглэлээр 6 цагийн сургалтад хамрагдаж Улаанбаатар хотын улсын тэргүүний 20-р сургууль, Шинэ-Эрин сургуулиар орж сургуулийнх нь үйл ажиллагаа, анги танхимын тохижилт, багш нарын бичиг баримт хөтлөлт, хүүхэд хамгааллын талаар хийж хэрэгжүүлж буй ажил, кабинетуудын ажиллагааг үзэж судалсан ба зөвлөх багш С.Болормаа багшийн сургалтын хэрэглэгдэхүүн хийх, ашиглах арга зүйтэй танилцлаа. Сургалтад оролцож туршлага судалсан багш нар сургууль дээрээ түгээн дэлгэрүүлэх сургалтыг 2 хоног хийсэн.

Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулан бага ангийн багш нар, тогоочид, няравын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний хариуг эрүүл мэндийн дэвтэрт бичүүлж баталгаажууллаа.

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

Сумын мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах, хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор 04-р сарын 11-нд Мал эмнэлгийн газрын даргаар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг суманд ирж хувийн хэвшлийн мал эмнэлгийн байр, унаа, бэлэн байдал, тоног төхөөрөмжийг шалгаж, халдварт өвчний зураглал, судалгаа зэргийг нарийн гаргахыг зөвлөж зааварчилгаа өгч ажилласан. Мөн малын эмийн худалдаа хийж байгаа ААН, дэлгүүрүүдэд малын эмийг хүнсний дэлгүүрт худалдахгүй байх, эмийг малын эмчийн хяналтан дор худалдан борлуулах талаар заавар зөвлөмж өгч ажилласан байна. Сумын мал сүрэгт 2020 онд хийх вакцин, биобэлдмэлийн захиалгыг ХХМЭҮН-ээс нэгтгэн авч аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

Шөвөг яраас урьдчилан сэргийлэх тарилгыг татан авч, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд хуваарилан өгч вакцинжуулалтыг эхлүүлээд байна.

Сумын ИТХурлын 2018.12.17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан 2019 оны ГЗБТөлөвлөгөөг газрын харилцааны мэдээллийн самбарт байрлуулан, иргэдэд сурталчлан ажиллаж байна. Мөн иргэдээс ирүүлж байгаа өргөдлийг хүлээн



авч, шийдвэрлэн ажиллахаас гадна энэ сард эзэмшил газрын хэмжээ талбайг өөрчлөх 2 өргөдлийг хүлээн авч, шийдвэрлээд байна. Мөн өргөдлийн төрөл 14-р 1 иргэний өргөдөл хүлээн авч бүртгээд байна. Сумын ИТХурлын 2018 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан газрын төлбөрийн итгэлцүүрийн дагуу газар эзэмшигч ИААНБ-уудын газрын төлбөрийн ногдуулалтыг гаргаж, ИААНБ-уудын 2019 оны газрын төлбөрийг төвлөрүүлж эхлээд байна.

Сумын эрүүл мэндийн төв аюултай хог хаягдлын цэг хийхтэй холбогдуулан Мөнххаан сумын аюултай хог хаягдлын цэгийг үзэж танилцсан.

Засгийн газрын 189-р тогтоол, Сумын засаг даргын А/23 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны тасаг ААН байгууллагаар нэг удаагийн нийлэг хальсан уут худалдан борлуулахгүй байх талаар мэдээлэл хийж, гарын авлага тарааж ажилласан. Мөн Сумын засаг даргын захирамжийн дагуу Төсөвт байгууллагуудын дунд 2 долоо хоногийн хугацаатай “Нэг төрийн албан хаагч хоёр даавуун тор” уралдаан зарласан, Мөн Хүүхдийн цэцэрлэг, ЕБС, Эмнэлэг зэрэг гал тогоотой албан байгууллагуудад хуванцар сав, хуванцар шанаганы хор уршгийн талаар мэдээлэл өгч усны эко сав болон металл шанага, халбага хэрэглэж байхыг зөвлөж ажилласан

#### Түмэнцогт сумын сарын ажлын товч мэдээ:

##### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

Засаг даргын 2019 оны А/27 тоот захирамжаар Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн оношилгоо явуулах ажлын хэсгийг томилж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Засаг даргын 2019 оны А/30 тоот захирамжаар Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал цэвэрлүүлэх, сэг зэм ачих, тээвэрлэх, булж устгах ажлыг зохион байгуулж Засаг даргын нөөц сангаас 647400₮ зарцуулж сэг зэм 72 бод мал, 64 бог мал нийт 20 га газрыг цэвэрлэж, 50тн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүллээ.

Засаг даргын 2019 оны А/34 тоот захирамжаар Хүнсний худалдаа эрхлэгч ААНэгж нь Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй малын эм, эмнэлгийн хэрэгслийг зориулалтын бус цэгт худалдан борлуулж байгаа эсэхэд хяналт шалгалт хийсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10 сая төгрөгөөр мэрэгч амьтан устгах 2тн хорыг захиалан авчирч Лхүмбэ, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт цацах ажлыг малчны бүлгүүд багийн Засаг дарга нар хамтран хэрэгжүүллээ.

ЗДТГ-ын албан хаагчдын хувийн хэргийг ТАЗ-ийн 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар заасан журмаар шинэчлэн хөтлөх журмын дагуу шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Тамгын даргын 2019-04-25-ний өдрийн А/06 тоот тушаалаар томилж 05 сарын 20-ны дотор хувийн хэргийн бүрдүүлэлтийг бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг ТАЗөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын журамд заасны дагуу албан тушаал тус бүрээр шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Тамгын даргын 2019-04-19-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

##### *Төсөв, санхүүгийн чиглэлээр:*

Төсөвт байгууллагуудын санхүүгийн дэмжлэгийг хуваарийн дагуу санхүүжүүлэн ажилласан. Орон нутгийн үйл ажиллагааны орлого 440.9, шууд бус орлого 26.6, хөрөнгө борлуулсны орлого 8623.4, улсын тэмдэгтийн хураамж 185.1, хүү торгуулийн орлого 3659.0 нийт 12935.0 төгрөг.

Орон нутгийн 4 сарын санхүүгийн дэмжлэг 28662.0 мянган төгрөг олгогдоод байна.

Сумын байгууллагуудын албан хаагчдын дунд “Архи, тамхи бидний сонголт биш” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан зарлаж нийт 14 байгууллага, ААНэгжид удирдамжийг хүргүүлсэн одоогоор 12 материал ирээд байна. Уралдааны дүнг 05 дугаар сард гаргаж нийтэд танилцуулах бөгөөд уралдаанд шалгарсан 3 саналыг ажил хэрэг болгож хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөөд байна.

*Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:*

Эрүүл мэндийн төвийн амбулаториор 410 иргэн, алсын дуудлага 6 ойрын дуудлага 45 үйлчлэгч үйлчлүүлсэн байна. 0-5 насны хүүхдүүдийг товлотт вакцинд 100 хувь хамрууллаа. Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд 30 иргэн, Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 87 иргэн, Артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 50 иргэн хамруулаа. 7,14 настай 78/78 хүүхдийг сахуу татрангийн вакцинд бүрэн хамрууллаа. Хачигт халдвартын вакцинд Эрэн хайх аврах бүлгийн 15 ажилчин хамрагдсан. Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 65 сурагч хамрагдсан.

Давсны хэрэглээг бууруулах сарын аяны хүрээнд халамжийн байцаагчтай хамтран хүнсний талон авдаг 20 иргэнд сургалт сурталчилгаа хийсэн.

1-р багаар тойрон 110 ард иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийж 12 хөтөлбөрийн хүрээнд сургалт сурталчилгаа хийлээ.

Like life-эрүүл жаргалтай монгол клубийн эмч нар ард иргэд болон албан байгууллагын ажилчдад зөв зохистой хоололт, халдварт бус өвчний талаар сургалт хийсэн.

Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйланг хичээллэн тогтмолжуулан бага бүлэг, ахлах бүлэг гэсэн 2 насны ангиллаар монгол ардын бүжгийн дасгал хөдөлгөөнийг зааж байгаа ба дугуйланд бага бүлэгт 20, ахлах бүлэгт 10 сурагчид хамрагдаж байна. Насанд хүрэгчдэд зориулан хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор өдөр бүр Зумба фитнес бүжгийг хичээллэн нийт 8 иргэн хамрагдаж байна. Нутгийн бахархал болсон бүжгийн багшийг алдаршуулах Монгол ардын бүжгийн сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, бүжгээр дамжуулан урлагийн боловсрол олгох зорилгоор 10 дахь жилдээ монгол улсын соёлын тэргүүний ажилтан, бүжиг дэглээч Балжирын Жаргалсайханы нэрэмжит “БИД БҮЖИГЛЭХ ДУРТАЙ”-2019 хүүхдийн бүжгийн наадмын удирдамж 4 дүгээр сарын 29-нд зохион байгууллаа.

4-р сард сумын орон нутгийн музей үйлчилгээгээр насанд хүрэгчид 9, хүүхэд 16 нийт 25 хүн үзэж сонирхон танилцсан байна. Музейн үзмэрийн тооллогыг Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музейн мэргэжилтнүүд 4-р сарын 18-нд ирж ажиллан нийт 109 үзмэрийг улсын бүртгэлд бүртгэн авч баримтжууллаа. Монгол Улсын Гавьяат Зоо Техникч Д.Лхагвасүрэн ОНСМузейд өөрийн гаргасан “Итгэл зүтгэлийн он жилүүд” ном, 2ш баярын бичиг зэргийг хандивлалаа. Мөн Засаг даргын Тамгын газраас сум орон нутгийн холбогдолтой баярын бичиг, диплом, үнэмлэх зэрэг 32 ш зүйлийг хандивлалаа. Орон нутаг судлах үзмэрийн тооллогод шинээр дээл 3 ш, ууж 1ш, малгай 1, ёочин 1, шанз 1, ооль 1, модон хүрз 1, зэс алх 1ш зэрэг 16 ш эд өлгийн зүйлийг нэмж бүртгүүлээ.

Номын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж, энэ сард нийт 120 иргэнд 190ш ном, үүнээс танхимаар 91иргэнд 120ш ном олгож, гэрээр насанд

хүрэгчдэд 12 иргэнд 23 ш, 17 хүүхдэд 47ш ном олгож үйлчиллээ. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан “Уншлагын 7 хоногийн аян”-г зохион байгуулж нийт 1-5-р ангийн 80 сурагч хамрагдсан баг анги бүр нэг гадаад уран зохиол сонгож уншсан номын тухай ярилцаж ханын сонин, том ном, жижиг ном бүтээж тухайн номыг сурталчиллаа. Мөн “Нэг ном нийтийн тусад” хандивын аянг зохион байгуулж нийт 54ш ном хандиваар ирлээ. Мөн соёлын төвийн хүлээлгийн танхимд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг зохион байгуулж үзэсгэлэнд хүүхдийн ном 65, гадаад ном 24, шинэ ном 31-ыг дэлгэн 120 ш номыг дэлгэн 150 иргэдэд үйлчилсэн байна. ЕБС-ийн номын сантай хамтран Гадаадын уран зохиолын номын нээлттэй үзэсгэлэнг ЕБС-ийн зааланд зохион байгуулж нийт 200 гаруй багш суралцагчид үзэж сонирхсон байна.

Аймгийн үйлдвэрчний эвлэлийн тэргүүлэгч О.Батзаяагаар ахлуулсан ажлын хэсэг ирж цэцэрлэгийн нийт багш ажилчдад ҮЭ-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, цэцэрлэгийн ҮЭ-ийн тэргүүлэгчдийг сонголоо.

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор багуудын засаг дарга нартай эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдан авлага үүсгэсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч малчдын эргэн төлөлтийг барагдуулах сарын аяны хүрээнд “Малжуулах хөтөлбөр”-т хамрагдсан 2 иргэнтэй холбогдож нийт 300,000 төрөгний эргэн төлөлтийг хийлгэсэн. ХБИргэний ажлыг байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэнээр 360,000 төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэнээр 150.000 төгрөгийг тус тус хийлгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн талаар, сургалт сурталчилгааны талаар Зорилтот бүлгийн өрх болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхүүд, 1-р багийн 43 өрхөөр явж мэдээлэл хийн малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийн материалыг хүлээн авсан.

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр:*

МЭГазарт Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын цуваа холбогдох материалыг аж ахуйн нэгжээр нь баталгаажуулан холбогдох газарт хүргүүлээд байна.

Малчин болон мал бүхий иргэдэд өвөлжөө хаваржааны хашаа хороог ариутгах халдваргүйжүүлэх талаар заавар зөвлөгөө өгөн гарын авлага тараан ажиллаа.

Уулбаян сумын сарын ажлын товч мэдээ:

*Төрийн удирдлагын чиглэлээр:*

МУ-ын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний” жил болгон зарласантай холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, өрх бүрд хүрч үйлчлэх зорилгоор хөдөөгийн 4 багийн 360 өрхөд ОНХС-ын журам, нийгмийн даатгал, халамж, эрүүл мэнд, мал эмнэлгийн тухай хууль тогтоомжийг сурталчлан гарын авлага тарааж ажилласан.

4-р сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 12654,1 мянган төгрөг орохоос 14797,0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 117,0 хувийн биелэлттэй.

Ахмад хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх спорт чийрэгжүүлэлтийн тоглоомын талбай, гудамжны гэрэлтүүлэг зэргийн төсөв зургийг хийлгүүлсэн. Аймгийн Шарга

ХХК-иар Тэгш, Жавхлант багийн төвийн барилгыг, Дэлгэр багийн төвийн барилгыг Лхатоном ХХК-иар бариулах гэрээ байгуулаад байна.

2019 оны 4 сарын байдлаар төрөлт 12, нас баралт 9, гэрлэлт 1, иргэний үнэмлэх сунгалт 26, шинээр олгосон 9, шилжин ирсэн 6 бүртгэгдсэн байна.

*Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалл, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:*

Хоолны хордлогын талаар сургалт, Монгол бичгийн сургалт, цэвэр бичигтэн уралдааныг зохион байгуулж нийт 47 хүнийг хамруулсан байна.

Хүүхдийн цэцэрлэгийн барилгын коридорын засварыг гүйцэтгэж, байгууллагын гадна, дотно их цэвэрлэгээг зохион байгууллаа.

“Шувуухай-2019” наадмыг зохион байгуулж, хүүхдүүдийн 84%-ийг хамруулсан.

“Сайн хичээл-Үйл ажиллагаа”-г зохион байгуулж тайланг БСУГ-т тайлагнаж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хүн амын эрүүл мэнд, гоо зүйд хөрөнгө оруулалт хийж “Нийтийн цэнгээнт” бүжгийг 7 хоногийн 1 дэх өдөр тогтмол зохион байгуулж байна.

Инээдмийн баярын өдрийг тохиолдуулан явуулсан хөтөлбөрт арга хэмжээнд 120 гаруй иргэн хамрагдлаа.

04-р сарын 11-нд Баруун-Урт хотноо зохион байгуулагдсан Соёл урлагийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд Соёлын төвийн номын санчийг оролцуулсан.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 2018 онд "Малжуулах төсөлд" хамрагдсан 4-н иргэний 3090000 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүллээ.

Залуучуудын гарааны безнисийг дэмжих төслийн хүрээнд 10 иргэнийг ямаа самнах ажилд зуулчилж, 1230 ямаа самнаж 6765000 мянган төгрөгийн цалин хөлс авсан байна.

ХАБЭА-ын сарын аяны хүрээнд зөвлөлийг хуралдуулан ажлын төлөвлөгөөг батлан ЕБС, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд ХАБЭА-ын ажилтан ажиллуулах талаар албан бичиг гарын авлага хүргүүлсэн. Байгууллага бүрт 1 ажилтнаар ХАБЭА-ын ажлыг хавсарган гүйцэтгүүлэхээр болоод байна. 04 сарын 25-ны өдөр албан байгууллагын дарга, ХАБЭА хариуцсан ажилтан, галч нарыг хамруулсан сургалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хамтарсан багт Цагдаагийн хэсгээс ирсэн саналын дагуу 04 сарын 24-нд гэр бүлийн хүчирхийллийн тухай, зорилтот өрхийн хувийн хэргийг тус тус нээж бүрдүүллээ.

Гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 15 өрхөөс гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ авч, 33 хүүхдээс эрсдэлийн үнэлгээ авч ажилласан.

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 147186.3 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүллээ. Үүнээс: Ажил олгогчоос шимтгэлд -104339.7 мян төг, сайн дурын даатгалын шимтгэл- 27590.3 мян төг, ЭМДаатгалын шимтгэлд- 15256.3 мян төг, хэлтсээс 374.0 сая төгрөгийн санхүүжилт авч 387 тэтгэвэр авагчдад 483697.6 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДД-д 138 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 27590.3 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 134 даатгуулагчийг даатгаж 15256.3 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Нийт 422 хүн эмнэлгийн үзлэгт хамруулсны дотор амбулаторид 263 урьдчилан сэргийлэх үзлэгээр 131 хүн, идэвхитэй диспансерийн хяналтад 6, гэрийн идэвхтэй хяналтад 26, гэрийн дуудлагаар 30 хүн үзэж, 27 хүн хэвтүүлэн эмчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлээ. Эмнэлэгт 34 өвчтөн шинээр хэвтүүлэн эмчилж, алсын болон ойрын дуудлагад 45 удаа, явж үйлчилсэн. Жирэмсний хяналтад 25 эхийг тогтмол хянаж, 0-5 насны 90 хүүхдийг хяналтад үзэж жинлэн, 0-2 насны 18 хүүхдийг урьдчилан сэргийлэх тарилганд хамрууллаа.

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, чиглэлээр:*

ЕБС-н 6-р ангийн 36 сурагчийг Эко анги бүлэг болгож аймгийн 3-р сургуулийн Эко бүлгийн 6 сурагчийг урьж сумын Эко бүлгийн сурагчдад туршлага судлуулж мөн үйл ажиллагаагаа хэрхэн явуулж болох талаар дадал сургалтыг зохион байгууллаа.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сурталчлан таниулах ажлын хүрээнд сумын групп болон дотоод группд мэдээ мэдээллийг тавьж, мөн газар хөдлөлтийн үед бэлэн байх арга хэмжээний дадал сургуулилтыг сумын хэмжээнд зохион байгуулж холбоо зарлан мэдээллийн үүргийг гүйцэтгэж төрийн банкнаас зөвшөөрлийг нь авч сэрээн дохиог ажиллуулж ирц цугларалтыг ханган аранзны үзлэг шалгалтыг хийлээ.

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний Хэлтсийн нийтийг хамарсан ажилд хог цэвэрлэх, мод тарих, булгын эх хашиж засварлах 3 төслийг бичиж хүргүүлээд байна.

Сумын нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 компанитай хамтран ажиллах гэрээг байгуулан ОНХС-д 100 сая төгрөгийг төвлөрүүлэхээр болсон.

Сумын төвд Хийдийг тойруулан шинээр 8,4 га-д хашаа татаж ногоон төгөл үүсгэх ажлыг нутгийн Хүндэт иргэн Эрдэнэхүүгийн санаачилга, хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчид, аж ахуйн нэгж, зорилтод бүлгийн өрхийн хүчээр 2000 гаруй модны нүхийг ухаж бэлтгээд байна.

150 м шлангыг 825000 мянган төгрөгөөр худалдан авч ногоон байгууламжийн усалгааг эхлүүлээд байна.

Худаг гаргах зөвшөөрлийн бичиг аваагүй гүн өрмийн худаг гаргасан 1 иргэнийг 150000 төгрөгөөр торгож, татварын дансанд 240000 төгрөгийг төвлөрүүллээ.

#### Халзан сумын сарын ажлын товч мэдээ:

##### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

Аймгийн сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын туршлага солилцох уулзалт, спортын нөхөрсөг тэмцээнд сумын ИТХ-ын ажлын алба төлөөлөгчид ажилттай оролцож ирсэн.

04 дүгээр сарын 01, 02 ны өдрүүдэд Засаг дарга 2 дугаар багийн малчидтай уулзаж, иргэдийн санаа бодлыг сонсож төл бойжилттой газар дээр танилцан ажиллалаа.

04 дүгээр сарын 11-ний өдөр аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар, ИХТ Г.Мөнхзаяа нар 2018 оны ажлын тайлан, 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлаараа тайлан тавьж 80 гаруй иргэд хөдөлмөрчтэй уулзаж, тэдгээрийн санаа бодлыг сонслоо.

04 дүгээр сарын 22-ны өдөр Шинээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэлийг хангуулах чиглэлээр Аймгийн Засаг даргын 04 дүгээр сарын 10 өдрийн захирамжаар байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллалаа.

04 дүгээр сарын 25 ны өдөр цэрэг татлага болж 26 -41 хүртэлх насны иргэд мөнгөн төлбөрөө тооцуулж, 26 хүртэлх насны иргэд комиссдоо орлоо.

Ахмад настны зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг соёлын төвд 16 ахмад настанд, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны биенэсийг дэмжих хөтөлбөрийг Иргэний танхимд 15 иргэнд, ХАБЭАхуйн сарын аяны нээлтийн сургалтыг иргэний танхимд 25 иргэнд, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр сургалтыг иргэний танхимд 15 иргэнд тус тус хөдөлмөр халамжийн мэргэжилтэн зохион байгуулан ажиллалаа.

##### *Боловсрол, Соёл, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд*

Ерөнхий боловсролын 1 ангид элсэн орох сурагчдыг бүртгэн 4-р сарын 1-ээс 14 хоног бэлтгэл бүлэг хичээллэж, 35 хүүхэд хамрагдав.

СУИС-ийн багш нарыг 10 хоногийн турш урин ажиллуулж Уртын дуу, морин хуур, үндэсний хөгжим, монгол бүжгийн сургалтыг авлаа. Үүнд Уртын дууны төрөлд 5, Морин хуурын төрөлд 2, Үндэсний хөгжмийн төрөлд 4, монгол ардын бүжиг 20 иргэн хамрагдсанаас

12 насанд хүрэгч, 8 хүүхэд хамрагдсан байна. 10 хоногийн сургалтын дараа суралцагчид тайлангаа иргэдэд тавьж өндөр үнэлгээ авлаа.

Дэлхийн номын өдөрт зориулан Номын үзэсгэлэн гаргаж 54 иргэнд үйлчилж ажилласан. Мөн Уншигчийн цаг” арга хэмжээг ЗДТГ-д зохион байгуулж ажилчдад карт нээж ном олголоо. ЕБС-ийн 6-9-р ангийн сурагчдын дунд Монголын нууц товчоонд нэвтрэхүй” тэмцээнийг зарлаад байна.

Төрийн болон төрийн бус байгууллагын ажилчдын дунд заавал сурах 10 бүжгээр тэмцээн зохион байгуулж 12 хос амжилттай оролцлоо.

Хөдөлмөрийн мэдээллийн санд ажил хайгч 10 иргэнийг бүртгэж, 13 иргэнийг түр ажлын байранд зуучиллаа. Шинэ ажлын байр 13 гарсан байна. Ахмад настны зөвлөх үйлчилгээнд 2 төсөл хүргүүлж, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн сургалтад 2 иргэнийг хамрууллаа. ХАБЭАхуйн сарын аяны нээлтийг зохион байгуулан 5 удаагийн сургалт хийлээ. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр сургалтыг залуучуудад, Ахмад настны зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр сургалтыг ахмадуудад, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр 2019 сургалтыг зорилтот бүлгийн иргэдэд зохион байгууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төсөл хөтөлбөрийн эргэн төлөлтийн сарын аяныг зохион байгуулан тайланг хүргүүлсэн. Соёлын төвийн шинэ барилгын ажилд ажиллаж байгаа иргэд болон албан газруудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийж арга зүйн зөвлөгөө өглөө. МСҮТөвтэй хамтран ХАБЭАхуйн хуулийн сургалтыг зохион байгууллаа.

Зорилтот өрхийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж байнгын асаргаатай иргэдийн гэрээр орж эрүүл мэндийн үзлэг хийж хуулийн хэрэгжилтийн талаар хяналт тавин ажиллаа.

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, чиглэлээр:*

Төсөвт 5 байгууллага, 6 аж ахуй нэгжид галын аюулгүй байдлын үзлэг шалгалтыг зохион байгуулж ажиллалаа. Мөн тусгай хог хаягдалд хяналт тавьж шар ууттай хог 89,6, аюулгүйн хайрцаг 10,4, бусад хог хаягдал 276 кг-ийг зориулалтын дагуу устгалаа.

04-р сарын 23-ны байдлаар нийт 25 зээлдэгч байгаагаас 14 хүнээс 6,427,147 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлдэгч 1 иргэн 1,024,300 мянган төгрөгийг Сум хөгжүүлэх сангийн дансанд төлж зээлээ хаасан.

Дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих зорилгоор 70 хурга, 30 ишгийг өсвөр хээлтүүлэгч тавихаар малчидтай тохиролцож, тэмдэглэгээ хийлээ.

Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх зорилгоор 17 малчнаас Бактержуулсан будааны захиалга авч, Улаанбаатар дахь “Шим” ХХК-аас 470 кг бактержуулсан будааг авчирч сумын 4-р багийн нутаг Алтад, Хадан хошуу, Хашаат, Дэмбэрэлийн баруун урд ширээ, 2-р багийн нутаг Бумбат, Бор хошуу, Сахиулын дэрс, Ясан гэх газруудаар цацаж ажиллалаа. Мөн 4, 1, 2-р багийн нутагт ашиглаж байгаа худгийн судалгаа авч, байршил, солиболцлыг нь тогтоолоо. Төл бойжилт 70 гаруй хувьтай бойжиж байна.

4 дүгээр сарын 10 нд Аймгийн МЭГ-аас МУ-д “Мал амьтны тухай хууль” батлагдан гарч 2019 оноос шинэ бүтэц тогтолцоогоор ажиллаж байгаатай холбогдуулан сумдын удирдлагууд, МЭТ, МЭҮН, малчидтай уулзаж мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хувийн хэвшлийн мал эмнэлэгүүдийн үйл ажиллагаатай танилцаж MNS5368:2018 стандартын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Сум болон хөдөө багийн малын дуудлага 4-р сарын 1-ээс 4-р сарын 23-ныг хүртэл 40 дуудлага ирсэн үүнээс дийлэнх нь эрдсийн дутагдал малчны арчилгаа маллагааны сул байгаагаас үүдэлтэй малаа дор орсон хойно нь өгсөн дуудлага зонхилж байна. Эмчилгээ, зөвлөгөө өгч ажилласан.

4 дүгээр сарын 11-нд 3-р багт нутагладаг 6 сууриар тойрч малд үзлэг хийж арчилгаа маллагаагаа сайжруулах тал дээр зөвлөгөө мэдээлэл хийлээ мөн эмийн зохисгүй хэрэглээний талаар заавар журам танилцууллаа.

4 дүгээр сарын 15-нд Сумын 3-р багаас 10 цусны шинжилгээ, 2 дээжийг МЭГ-ийн лабораторид хүлээлгэж өгсөн.

4 дүгээр сарын 14-нд ГХБХБГазарын 2 мэргэжилтэн ирж 5 айлын кадастрын зураг, шинээр баригдах цэцэрлэгийн барилгын кадастрын зургийг хийж бэлэн болголоо.

4 дүгээр сарын 21-нд сумын төвийн бүх албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хашаа байшинг бүрэн хаягжуулж дууслаа.

#### Эрдэнэцагаан сумын сарын ажлын товч мэдээ:

##### *Төрийн удирдлагын чиглэлээр:*

Аймгийн мэргэжлийн хяналтын газраас 04 дүгээр сарын 19-с эхлэн суманд 3 өдөр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийж ажиллалаа. Үүнд Мэргэжлийн хяналтын газраас 11 салбарын хяналтыг Төлөвлөгөөт 34 аж ахуй нэгж, Төлөвлөгөөт бус 7 аж ахуй нэгжээр шалгалт хийж нийт 406 зөрчил дутагдал илэрсэнээс 214 зөрчлийг газар дээр нь арилгаж 50 хувийн үзүүлэлттэй байна. Үлдсэн зөрлийн хүрээнд 228 заалттай 22 албан шаардлага, 2 акт, 3 дүгнэлтийг гаргаж 3 аж ахуй нэгж иргэнд 3 100 000 төгрөгийн торгууль тавьж ажиллалаа.

04 дүгээр 22-ноос 25 ны хооронд Авто тээврийн үзлэгийг хийж 613 авто тээврийн хэрэгслийг хамруулж 20.3 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

##### *Боловсрол, Соёл, Эрүүл мэнд нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд*

4 сарын 20нд Сүхбаатар аймгийн хэмжээнд ЕБСургуулийн 9-н сургуулийн дунд зохион байгуулагдсан Цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнд 3-р байрыг эзэллээ. Соёлын төвөөс 4-р сарын 1 буюу Инээдмийн баярт зориулсан “20.000 инээдтэй-Ёндоотой хавар” арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. 20.000-н инээд Шоунд Өндөр настан Мөнхөө тэргүүн байрыг эзэлж шагналын эзэн болсон. Нийт 180 хүн үйл ажиллагааг үзэж сонирхсон байна.

Заавал сурах Нийтийн-16 бүжгийн сургалтыг эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалтад залуучууд 30, ахмад 20 хүн хамрагдаж бүжгээ амжилттай сурлаа.

Нийгмийн даатгалын байцаагч Ө.Гэрэлчимэг, Ц.Урантуяа нар хөдөөгийн 5 баг, сумын төвийн 2-р багийн айл өрхөөр орж цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийж, Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн хууль, малчны тэтгэврийг сурталчлах, Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, орлого төвлөрүүлэх чиглэлээр ажиллалаа. 5 багийн нийт 499 өрхийн 1600 гаруй иргэнд Сайн дурын даатгал, Эрүүл мэндийн даатгалаар яриа хийж малчны тэтгэврийн сурталчилгааны материал тарааж, утасны дугаар, гарын үсэг зуруулан баталгаажуулан ажиллалаа. 4-р сарын 24-ны байдлаар Эрүүл Мэндийн даатгалд 247 иргэний 11,613,874 төгрөг, СДД-д 182 иргэний 40,927,885 төгрөгийн шимтгэл төлүүлснээс 41 иргэнийг шинээр хамруулсан байна. Нийт 52,541,759 төгрөгийг дансанд төвлөрүүлэн ажилласан. Малчнаар тэтгэвэрт гарах 2 иргэний материалыг хүлээн авч Малчны зөвлөлийн хурлаар оруулан дэмжигдэж дээд газарт хүргүүлсэн. Мөн гар утасны апплекшин 120 иргэнд суулгаж ажилласан. Шинээр 1 ажил олгогч хамрууллаа.1 ажил олгогчийг тоон гарын үсэгт хамруулсан. Ахмадын хороотой хамтран ажиллаж 2 удаа ахмадуудтай уулзаж зөвлөгөө өгсөн.

04-р сарын 03 нд Сүхбаатар аймагт “Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн анхдугаар зөвлөгөөн”-д сумын 1, 2-р цэцэрлэгийн эрхлэгч, ЭМТ-ийн нийгмийн ажилтан, Сургуулийн захирал, нийгмийн ажилтан, дотуур байрын 2 багш, НТБН-ийн багш, Цагдаагийн тасгийн дарга, 2 төлөөлөгч 12 хүний бүрэлдэхүүнтэй явж оролцсон. 04-р сарын 08 нд 4-р

сард хийх мөн 2-р улиралд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 26 зүйл заалттайгаар боловсруулж Тамгын газрын даргаар батлуулсан.

Сум багийн нийт хүн амын 20%-ийн мэдээллийг багийн дарга нартай хамтран шинэчилсэн хүн ам, өрхийн бүртгэлийн хуудсаар цуглуулан нягталж, сайжруулах ажлыг 03.25-наас 04.08-ны хооронд зохион байгуулж ажиллалаа. Үүнд 227 өрхийн 1238 иргэний мэдээллийг шинэчилж бүртгэсэн байна. Илтгэх хуудсыг 4-р сарын 08 нд цахимаар Статистикийн хэлтэст явуулсан.

04 дүгээр сарын 09-нд 15-40, 2546 иргэний нэрчилсэн дэлгэрэнгүй судалгааг баг тус бүрээр ЭМТ-д гаргаж өгөв.

04 дүгээр сарын 15, 19, 24-ны өдрүүдэд Хамтарсан багийн хурал хуралдаж гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр хийх 21 заалт бүхий жилийн ажлын төлөвлөгөө, төсвөө хэлэлцэн баталж, Хамтарсан багийн гишүүдтэй багийн ахлагч Нууцын гэрээ байгуулж ажиллалаа. Хамтарсан багийн ажлын төлөвлөгөө, нууцын гэрээ, тогтоол, дэлгэрэнгүй судалгаа зэргийг цаасаар 04.23 нд аймгийн ГБХЗХГ-т явуулсан.

*Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, чиглэлээр:*

4 сарын 01 нд шүлхийн өвчин гарсан 2 хот айлын хотонд эцсийн ариутгал хийж хорио цээрийн дэглэм бууруулж ажиллалаа. 7-р багт вакцины хяналт шалгалт хийж айл өрхөөр орж мал амьтаны Эрүүл мэндийн тухай хуулийг сурталчилан мөн халдварт болон халдваргүй өвчний гарын авлага 187 ширхэгийг тараасан. Шүлхийн тарилга нийт 441 хот айлын үхэр-27073, хонь-141066, ямаа-145921 нийт- 314060 мянган толгой малд тарилга хийгдээд байна. Тарилганы хугацаа: 2019.03.08-2019.04.08 хооронд хийгдсэн байна. Зарцуулсан вакцин 342,600 л хэвийн хорогдол-1000л зарцуулсан байна. Аймгийн мал эмнэлгээс ажлын хэсэг гаран мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдээр явж зөвлөн туслах үйл ажиллагаа явууллаа. Мэргэжлийн хяналтын газраас төлөвлөгөөт шалгалтыг 5 мал эмнэлэг, 1 малын эмийн санд шалгалт хийлээ шалгалтаар гарсан зөрчилыг арилгаж ажиллалаа. Үүнд: 2 аж ахуй нэгж бага эрсдэлтэй /үнэлгээний хуудсаар/, 1 аж ахуй нэгж дунд эрсдэлтэй, 1 мал эмнэлэг-500 мянга төгрөгөөр, 1 эмийн санг 100 мянган төгрөгийн торгууль тавьсан. Үзэмчин хонь ХХК МХГазарт өргөдөл өгч татан буугдахаар болсон.